



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 28 (457)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим уяачдад Улсын алдарт уяач цол олгох тухай*
- *Үндэсний сурын харваачдад цол олгох тухай*
- *Улсын аварга цол олгох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*
- *Тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны долдугаар сарын 28

№28 (457)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛОГЧИЙН ЗАРЛИГ

464.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 195	803
465.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 196	803
466.	Лхамсүрэнгийн Чойжилсүрэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 197	803
467.	Адуучийн Гантогтоход Монгол Улсын гавьяат бсш цол хүртээх тухай	Дугаар 198	803
468.	Шагдарын Дашцэрэнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 199	804
469.	Чимбэгийн Сугар-Очирт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 200	804
470.	Дашийн Бямбасүрэнд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай	Дугаар 201	804
471.	Жамбын Пүрэвт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 202	804
472.	Ажханы Болатад Монгол Улсын байгаль орчны гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 203	805
473.	Сэрээтэрийн Батмөнхөд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 204	805
474.	Даваасамбуугийн Будад Монгол Улсын гавьяат мал зүйч цол хүртээх тухай	Дугаар 205	805
475.	Жанжаадоржийн Рагчаад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 206	805
476.	Гарамжавын Сандуйжавт Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай	Дугаар 207	806
477.	Чинэгийн Галсанд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 208	806
478.	Цэрэндоржийн Борхүүд Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай	Дугаар 209	806
479.	Цэндийн Цэцгээд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 210	806
480.	Алтангэрэлийн Бадарчинд Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээх тухай	Дугаар 211	807
481.	Лувсандоогийн Мөнхөөд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 212	807
482.	Бямбасүрэнгийн Шаравыг "Чингис хаан" одонгоор шагнах тухай	Дугаар 213	807
483.	"Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 215	807
484.	Франциско Ривера-Батизийг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 218	808
485.	Жамсрангийн Бямбадоржид Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай	Дугаар 228	808
486.	Раднаасүмбэрэлийн Гончигдоржид Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 229	808
487.	Цэрэнхүүгийн Шаравдоржид Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай	Дугаар 230	808

488.	Түвдэнгийн Очирхүүд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай	Дугаар 231	809
489.	Данзангийн Лүндээжанцанд Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай	Дугаар 232	809
490.	Мэндсайханы Энхсайханд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай	Дугаар 233	809
491.	Дэмбэрэлийн Төртогтоход Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 234	809
492.	Зарим хүнийг одонгоор шагнах тухай	Дугаар 235	810
493.	Санжбэгийн Төмөр-Очирт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 236	810
494.	"Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүндэт медаль"-иар шагнах тухай	Дугаар 237	810
495.	Нацагийн Багабандийг Сүхбаатарын одонгоор шагнах тухай	Дугаар 238	810
496.	Эрдэнэбатын Эрдэнэчулуун, Цэвээнжавын Дуламсүрэн нарт Улсын тод манлай уяач цол олгох тухай	Дугаар 239	811
497.	Гаваагийн Батхүү, Дагвадоржийн Цэрэнжигмэд нарт Улсын манлай уяач цол олгох тухай	Дугаар 240	811
498.	Зарим уяачид Улсын алдарт уяач цол олгох тухай	Дугаар 241	811
499.	Үндэсний сурын харваачдад цол олгох тухай	Дугаар 242	811
500.	Улсын начин цол олгох тухай	Дугаар 243	812
501.	Улсын харцага цол олгох тухай	Дугаар 244	812
502.	Улсын заан цол олгох тухай	Дугаар 245	812
503.	Улсын арслан цол олгох тухай	Дугаар 246	812
504.	Улсын аварга цол олгох тухай	Дугаар 247	813

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

505.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 118	813
506.	Хилийн заагийг тогтоох тухай	Дугаар 128	828
507.	Ажигд томилох тухай	Дугаар 132	828
508.	Тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 133	829

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

509.	Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 33	829
510.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 18, 9.2, 19 дахь заалтыг тайлбарлах тухай	Дугаар 34	835
511.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 114, 115 дугаар зүйлүүдийн зарим заалтыг тайлбарлах тухай	Дугаар 35	835
512.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 36	836

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 195

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан, Монгол Улсын Гадаад хэргийн сайдын саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Малайз Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

Лувсандоржийн Даваагивийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Малайз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Яйчилын Батсуурийг тохоон томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 196

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан, Монгол Улсын Гадаад хэргийн сайдын саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт

Элчин сайд Лувсандоржийн Даваагивийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Яйчилын Батсуурийг тохоон томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 197

Улаанбаатар хот

Лхамсүрэнгийн Чойжилсүрэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Утга зохиолын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж тууж, роман, эссэ-роман, дурдатгал, намтар өгүүллийн олон ном бүтээл туурвин Монголын утга зохиолын хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж зохиолч

Лхамсүрэнгийн Чойжилсүрэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Адуучийн Гантогтоход Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж монгол хэл бичиг, уран зохиолын хичээлийг ардын уламжлалт ёс зүйн аргыг орчин үеийн сургалттай хослуулан зааж, боловсролын шинэчлэлтэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн 93 дугаар

сургуулийн бага ангийн багш Адуучийн Гантогтоход Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

Шагдарын Дашцэрэнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Авто тээврийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний зохион байгуулалт, хяналт зохицуулалтыг сайжруулан, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжүүлэх алхмуудыг оновчтой хийж, нийслэлийн иргэдэд нийтийн тээвэрээр үйлчлэх үйлст оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн "Автобус-Г"

компанийн захирал Шагдарын Дашцэрэнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 200

Улаанбаатар хот

Чимбэгийн Сугар-Очирт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Мал аж ахуйн салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, тэмээн сүргийнхээ тоо толгойг тогтвортой өсгөж, үүлдэр угсааг сайжруулан чанаржуулж, сум багийнхаа малгүй өрхийг малжуулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, хөдөөд ядуурлыг бууруулах, сүү, цагаан идээний хангамжийг сайжруулах үйлсэд оруулж байгаа гарамгай хувь нэмрийг нь үнэлж

Баянхонгор аймгийн Баянлиг сумын 3 дугаар багийн малчин Чимбэгийн Сугар-Очирт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

Дашийн Бямбасүрэнд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллагад олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж, эдийн засаг, нийгмийн шинжилгээ, судалгааны онолын бүтээлүүд туурвиж, монгол орны эдийн засгийн амьдралыг зах зээлийн харилцаанд шилжүүлэн өөрчлөх, нийгмийн эрдчилсэн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг

нь үнэлж Монгол Улсын Ерөнхий сайд асан Дашийн Бямбасүрэнд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 202

Улаанбаатар хот

Жамбын Пүрэвт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монголын утга зохиолын салбарт түүхэн болон нийгэм аж байдлын сэдэвт олон эрван уран сайхны бүтээл туурвиж, монгол романы хөгжилд оруулсан онцгой хувь нэмрийг нь үнэлж зохиолч Жамбын Пүрэвт Монгол

Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

Ажханы Болатад Монгол Улсын байгаль орчны гавъяат ажилтан цол хүртээх тухай

Төрийн болон байгаль орчны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжууд түүний дотор газар болон усны эрх зүйн харилцааны шинэчлэлтийн үндсийг боловсруулж хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах үйл хэрэгт оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Байгаль орчны яамны Төрийн захиргааны газрын дарга Ажханы Болатад Монгол Улсын байгаль орчны гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 204

Улаанбаатар хот

Сэрээтэрийн Батмөнхөд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Шинжлэх ухаан, боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, дулааны энергетик, техникийн чиглэлээр эрдэм шинжилгээний шавь сургууль байгуулж, хүрээлэн буй орчны бохирдолд үнэлгээ өгөх, түүнийг бууруулахад чиглэгдсэн экологийн шинэчилсэн картуудыг зохиож судалгааны цуврал бүтээл туурвин, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

ШУТМС-ийн Дулааны техник үйлдвэрийн экологийн хүрээлэнгийн захирал Сэрээтэрийн Батмөнхөд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

Даваасамбуугийн Будад Монгол Улсын гавъяат мал зүйч цол хүртээх тухай

Төрийн захиргааны байгууллага, мал аж ахуйн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж малын чанар, үржлийн ажил үйлчилгээг сайжруулах, цөм торгон сүргийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, мал үржлийн албыг бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сүхбаатар

аймгийн Мал үржлийн албаны дарга Даваасамбуугийн Будад Монгол Улсын гавъяат мал зүйч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

Жанжаадоржийн Рагчаад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монголын радиод олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллахдаа Монголын радиогийн урын санг баяжуулахад үнэтэй хувь нэмэр оруулж, төр, засгийн бодлого шийдвэр болон улс орны бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээтэй мэдээлэл сурталчилгааг олон түмэнд хүргэх талаар идэвх зүтгэл гарган ажилласныг үнэлж Монголын

радиогийн "Гурван-Эрдэнэ" студийн нэвтрүүлэгч Жанжаадоржийн Рагчаад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Гарамжавын Сандуйжавт Монгол Улсын гавъяат малчин цол хүртээх тухай

Хурдан морь уях эрдэмд өөрийн хүч чадал, оюун ухаанаа дайчлан ажиллаж, олон арван уяач шавь нарыг бэлтгэхийн зэрэгцээ улсын баяр наадам, бүсийн, Засгийн газрын шийдвэрээр тэмдэглэж байгаа аймгуудын ойн баяр наадмуудаас 27 түрүү, 57 айраг авсан амжилтыг үнэлж

Нийслэлийн Налайх дүүргийн иргэн, тод манлай уяач Гарамжавын Сандуйжавт Монгол Улсын гавъяат малчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

Чинагийн Галсанд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Боловсрол, хэвлэл мэдээлэл, утга зохиолын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, утга зохиол, сэтгүүл зүйн бүхий л төрөл зүйлээр жинтэй олон арван бүтээл туурвиж, монголын утга зохиолыг гадаадад сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж зохиолч, сэтгүүлч Чинагийн

Галсанд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Цэрэндоржийн Борхүүд Монгол Улсын гавъяат уурхайчин цол хүртээх тухай

Уул уурхай, эрчим хүчний байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж уул уурхайн машин техникийг чадамгай эзэмшиж ажлын өндөр амжилт гаргахын зэрэгцээ залуучуудыг уул уурхайн ажил мэргэжилд сурган хүмүүжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Өмнөговь аймгийн "Таван толгой"

ХК-ийн жолооч Цэрэндоржийн Борхүүд Монгол Улсын гавъяат уурхайчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 210

Улаанбаатар хот

Цэндийн Цэцгээд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монголын радио, телевиз болон Улаанбаатар радиод нэвтрүүлэгчээр дөч гаруй жил ажиллахдаа радио, телевизийн нэвтрүүлгийн олон төрөл дээр мэргэжлийн өндөр ур чадвар гарган, улс орны түүхэн үйл явдал, төр, засгийн бодлого шийдвэр, нийгмийн шинэчлэл өөрчлөлт, улс орны ажил амьдрал, урлаг соёл, эрүүл мэндийн салбарыг хамарсан өргөн хүрээтэй мэдээлэл сурталчилгааг

олон түмэнд хүргэх талаар олон жил санаачилга, идэвх зүтгэл гарган ажилласан хувь нэмрийг нь үнэлж Улаанбаатар радиогийн нэвтрүүлэгч Цэндийн Цэцгээд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

Алтангэрэлийн Бадарчинд Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээх тухай

Хөдөө аж ахуй, боловсролын салбарт он удаан жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, сургалт-үйлдвэрлэл-дадлагыг хослуулан мэргэжилтэй ажилчид, мэргэжилтнүүдийг бэлтгэх, хөрс судлал, ургамал хамгааллын талаар судалгаа шинжилгээний ажил явуулж газар тариаланг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Төв аймгийн Баянчандмань сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн зөвлөх Алтангэрэлийн Бадарчинд Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

Лувсандоогийн Мөнхөөд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж сургалтын чанарыг сайжруулах, сургуулийн материаллаг орчин бүрдүүлэх, сурагч төвтэй сургалтыг зохион байгуулах, багш нарын заах аргыг, ур чадварыг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж Завхан аймгийн Алдархаан сумын ахмад багш Лувсандоогийн Мөнхөөд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

Бямбасүрэнгийн Шаравыг "Чингис хаан" одонгоор шагнах тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, олон симфони, удиртгал, магтуу, бүжгийн жүжгийн болон киноны хөгжим, нийтийн дууны ая зохиож, монголын орчин цагийн хөгжмийн урлагийг хөгжүүлж, Монгол Улсаа дэлхийн улс орнуудад сурталчлахад жинтэй хувь нэмэр оруулж байгаа болон Их Монгол Улс

байгуулагдсаны 800 жилийн ойн жилд "Чингис хаан" дуурь бүтээснийг үнэлж хөгжмийн зохиолч Бямбасүрэнгийн Шаравыг "Чингис хаан" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 215

Улаанбаатар хот

"Найрамдал" медалиар шагнах тухай

Хоёр орны парламентын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, хамтын ажиллагааны асуудлуудыг урагшлуулах, монголыг сурталчлахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж БНСУ-ын Үндэсний ассамблейн гишүүн, Үндэсний ассамблей дахь

Солонгос-Монголын парламентын бүлгийн дарга Жөн Жан Сен-г "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

Зарим хүнийг одонгоор шагнах тухай

Татвар, эрүүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан дор дурдсан хүмүүсийг одонгоор шагнасуугай.

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

Дамдинжавын Сэржмядаг - Орхон аймгийн "Алтан хундага" эмийн сангийн ажилтан

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Ядамын Аюушжав - Нийслэлийн татварын газрын хэлтсийн дарга

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 236

Улаанбаатар хот

Санжбэгзийн Төмөр-Очирт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Монгол Улсын Их Хурлын дарга, төрийн сайд, их, дээд сургуулийн багш зэрэг ажлыг олон жил үр бүтээлтэй хийж, парламентат ёсыг бэхжүүлэх, боловсролын шинэ тогтолцоог бүрдүүлэх, сургалт заах арга зүйг боловсронгуй болгоход оруулсан жинтэй хувь нэмрийг нь үнэлж

Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд Санжбэгзийн Төмөр-Очирт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 237

Улаанбаатар хот

"Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүндэт медаль"- иар шагнах тухай

Монгол Улсын ардчилсан хөгжлийг дэмжиж, хувь нэмэр оруулсан гадаад орны иргэн, улс төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэд, судлаачид, олон улсын байгууллагын ажилтан, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн баярын төрийн

хүндэт зочныг Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүндэт медалиар шагнасуугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 238

Улаанбаатар хот

Нацагийн Багабандийг Сүхбаатарын одонгоор шагнах тухай

Ардчилсан төрийн тогтолцоо, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үед Монгол Улсын Төрийн тэргүүнээр хоёр удаа сонгогдон ажиллаж улс орноо хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн тохиолдуулан Монгол Улсын

Ерөнхийлөгч асан Нацагийн Багабандийг Сүхбаатарын одонгоор шагнасуугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

Эрдэнэбатын Эрдэнэчулуун, Цэвээнжавын Дуламсүрэн нарт Улсын тод манлай уяач цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 3, 6 дугаар заалтыг үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ нь:

Монгол түмний цэнгэлийн манлай-Үндэсний их баяр наадмын болон шигшмэл, бүсийн хурдан морины уралдаануудад эрдэнэт хүлгийнхээ уяа сойлогыг тааруулан түрүү магнай, айргийн тавд хурдлуулж, наадамч олноо баясгасан Өвөрхангай

аймгийн Хайрхандулаан сумын харьяат, уяач Эрдэнэбатын Эрдэнэчулуун, Архангай аймгийн Хотонт сумын харьяат, уяач Цэвээнжавын Дуламсүрэн нарт Улсын тод манлай уяач цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 240

Улаанбаатар хот

Гаваагийн Батхүү, Дагвадоржийн Цэрэнжигмэд нарт Улсын манлай уяач цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 3, 6 дугаар заалтыг үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ нь:

Үндэсний их баяр наадмын болон шигшмэл, бүсийн хурдан морины уралдаануудад эрдэнэт хүлгийнхээ уяа сойлогыг тааруулан түрүү магнай, айргийн тавд хурдлуулж, уяачийн эрдэм чадвар, эв хавыг гайхуулсан Өвөрхангай аймгийн Хужирт

сумын харьяат, уяач Гаваагийн Батхүү, Улаанбаатар хотын харьяат, уяач Дагвадоржийн Цэрэнжигмэд нарт Улсын манлай уяач цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 241

Улаанбаатар хот

Зарим уяачид Улсын алдарт уяач цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 3, 6 дугаар заалтыг үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ нь:

Үндэсний их баяр наадмын болон шигшмэл, бүсийн хурдан морины уралдаануудад эрдэнэт хүлгийнхээ уяа сойлогыг тааруулан түрүү магнай, айргийн тавд хурдлуулан өндөр амжилт гаргасан дөр дурдсан хүмүүст Улсын алдарт уяач цол олгосугай.

1. Ломбын Алтангэрэл - Архангай аймгийн Ихтамир сумын харьяат, уяач
2. Чүлтэмийн Улаан - Сүхбаатар аймгийн Дарьганга сумын харьяат, уяач
3. Товуугийн Энхбат - Өвөрхангай аймгийн Бүрд сумын харьяат, уяач

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 242

Улаанбаатар хот

Үндэсний сурын харваачдад цол олгох тухай

Монгол Улсын "Үндэсний их баяр наадмын тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой, Ардын хувьсгалын 85 жилийн ойн баярын үндэсний сурын харваанд эрэгтэй харваачдаас 40 сум тавьснаас 34 онож түрүүлсэн Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын уугуул, "Бурхан Халдун" группийн харваач, спортын

мастер Хасагийн Болдбаатар, эмэгтэй харваачдаас 40 сум тавьснаас 35 онож түрүүлсэн Өмнөговь аймгийн Баяндалай сумын уугуул, "Монросцветмет" нэгдлийн харваач, спортын мастер Сэрээгийн Баярмаа нарт "Улсын мэргэн" цол тус тус олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

Улсын начин цол олгох тухай

Монгол Улсын “Үндэсний их баяр наадмын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1-д заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой, Ардын хувьсгалын 85 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 5 давсан дараах бөхчүүдэд улсын начин цол олгосугай.

1. Базаррагчаагийн Сэр-Од - Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын харьяат, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын бөх

2. Дондогийн Цогаолдорж - Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын харьяат, “Хүч” спорт хорооны бөх

3. Түрэндоржийн Өсөх-Ирээдүй - Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын харьяат “Алдар” спорт хорооны бөх

4. Намсрайн Баярмагнай - Говь-Алтай аймгийн Бигэр сумын харьяат “Хилчин” дэвжээний бөх

5. Мөнхсайханы Өсөхбаяр - Булган аймгийн Бүрэгхангай сумын харьяат, “Хилчин” дэвжээний бөх

6. Пүрэвдоржийн Ганхүү - Өвөрхангай аймгийн Бүрд сумын харьяат, “Хилчин” дэвжээний бөх

7. Баатарын Баянжаргал - Баянхонгор аймгийн Бууцагаан сумын харьяат бөх

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

Улсын харцага цол олгох тухай

Монгол Улсын “Үндэсний их баяр наадмын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой, Ардын хувьсгалын 85 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 6 давсан Сүхбаатар аймгийн Мөнххана сумын

харьяат, “Мон Нис” ХХК-ийн бөх Цэрэндашдоржийн Магалжав, Архангай аймгийн Булган сумын харьяат, “Хүч” спорт хороо, “Гарьд тур” ХХК-ийн бөх Мишэгийн Батжаргал нарт “Улсын харцага” цол тус тус олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 245

Улаанбаатар хот

Улсын заан цол олгох тухай

Монгол Улсын “Үндэсний их баяр наадмын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой, Ардын хувьсгалын 85 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 7 давсан Завхан аймгийн Нөмрөг сумын харьяат, Тагнуулын ерөнхий газрын “Эрч” клубийн бөх

Махгалын Баяржавхлан, Архангай аймгийн Булган сумын харьяат, “Хүч” спорт хороо, “Макс” группийн бөх Дамбийн Рагчаа, Төв аймгийн Аргалант сумын харьяат, “Очир-Ундраа” группийн бөх Дорлигжавын Амгаланбаатар нарт улсын заан цол тус тус олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 246

Улаанбаатар хот

Улсын арслан цол олгох тухай

Монгол Улсын “Үндэсний их баяр наадмын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 дүгээр заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой, Ардын хувьсгалын 85 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 9 давсан Өвөрхангай аймгийн Хужирт сумын харьяат,

Улаанбаатар хотын уугуул, “Үндэсний хөрөнгө оруулалтын банк”-ны бөх Долгорсүрэнгийн Сумъяабазар, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат, “Шивээ-Овоо” компанийн бөх Дагвадоржийн Азжаргал нарт улсын арслан цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 247

Улаанбаатар хот

Улсын аварга цол олгох тухай

Монгол Улсын "Үндэсний их баяр наадмын тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 дүгээр заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсан 800 жилийн ой, Ардын хувьсгалын 85 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 10

давсан Өвөрхангай аймгийн уугуул, Улаанбаатар хотын харьяат, "Үндэсний хөрөнгө оруулалтын банк"-ны бөх Долгорсүрэнгийн Сумъяабазарт улсын аварга цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 5 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 11.3, 24.2, 27.1, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.2, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.4, 7, 10-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Нийгмийн халамжийн сангийн дүрэм"-ийг 1 дүгээр, "Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох журам"-ыг 2 дугаар, "Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх, иргэнд тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг 3 дугаар, "Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг 4 дүгээр, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг 5 дугаар, "Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын гүйцэтгэх албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам"-ыг 6 дугаар хэвсрэлт ёсоор тус тус баталсугай.

2. Шинэчлэн батлагдсан Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэдэд даалгасугай:
а/төсвийн багцдаа багтаан шинэчлэн батлагдсан нийгмийн халамжийн талаархи хууль тогтоомжийг сурталчилж, хууль хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, холбогдох заавар, журам, аргачлал, маягтыг хэвлүүлэн түгээх, нийгмийн халамжийн ажилтан нарт зориулсан сургалт, семинарыг зохион байгуулах;

б/Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн чиг үүргийг боловсронгуй болгох арга хэмжээ авах.

3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай:

а/нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн хамгааллын талаар авах арга хэмжээ,

түүнд зарцуулах хөрөнгийн талаар санал боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах, нийгмийн халамжийн талаархи хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

б/Орон нутгийн ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтлэг эрх ашгийг төлөөлж чадах төрийн бус байгууллага болон сум, хороодын Амьжиргааг дэмжих зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагаанд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах асуудлыг судалж шийдвэрлэх;

в/Орон нутгийн амралт, рашаан сувиллын газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөнгөлөлттэй үнээр амруулж сувилуулах, иргэдийг төрөлжсөн асрамжид хамруулахдаа аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэж байх;

г/тухайн байгууллагад ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор хуульд заасан "Ахмадын сан" байгуулах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж байх;

д/сум, хорооны нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод Нийгмийн халамжийн тухай хуульд заасан чиг үүргийг нэмж тусгах талаар холбогдох арга хэмжээ авах.

4. Энэ тогтоолыг 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5. Энэ тогтоолыг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн "Нийгмийн халамжийн хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 36 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Л.ОДОНЧИМЭД

Засгийн газрын 2006 оны 118 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн халамжийн сан (цаашид "сан" гэнэ)-г бүрдүүлэх, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгө нь Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхэд зориулагдана.

1.3. Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Төрийн сангийн газартай хамтран гүйцэтгэнэ.

1.4. Нийгмийн халамжийн сангийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалтад хяналт тавих асуудлыг нийгмийн халамжийн болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

Хоёр. Сангийн бүрдүүлэлт

2.1. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгө нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

2.1.1. тухайн жилд нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулахаар улсын төсвөөс олгосон хөрөнгө;

2.1.2. тухайн жилд нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулахаар орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

2.1.3. сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банкинд зохих гэрээний дагуу хадгалуулсны хүүгийн орлого;

2.1.4. олон улсын байгууллага, гадаад орнуудаас өгсөн хандив, тусламж;

2.1.5. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс нийгмийн халамжийн зориулалтаар олгосон хандив, тусламж;

2.1.6. бусад эх үүсвэр.

Гурав. Сангийн хөрөнгийн төлөвлөлт, санхүүжилт

3.1. Нийгмийн халамжийн сан нь мөнгөн хөрөнгийн сан байх бөгөөд улсын хэмжээний төвлөрсөн сан, орон нутгийн дэд сантай байна.

3.2. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хүүхэд тэтгэмж олгох, хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулиудад заасны дагуу улсын төсвөөс нийгмийн хамгааллын арга

хэмжээнд зориулан хуваарилсан хөрөнгө нь нийгмийн халамжийн санд тусгай зүйл ангиар зохицуулагдана.

3.3. Нийгмийн халамжийн төвлөрсөн сангийн орлого, зарлагыг дараахь байдлаар төлөвлөнө:

3.3.1. аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллага нь дараагийн санхүүгийн жилд шаардагдах хөрөнгийн хэмжээг нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдах хүний тоо, тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээний төрлөөр нь ангилан дэд сангийн орлого, зарлагын хамт төлөвлөж жил бүрийн 3 дугаар сарын 5-ны дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ;

3.3.2. нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэг хүнд ногдох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, үйлчилгээний зардлын норм, норматив, стандартыг үндэслэн нийгмийн халамжийн сангийн орлого, зарлагыг улсын хэмжээгээр нэгтгэн төлөвлөж, 3 дугаар сарын 20-ны дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ;

3.3.3. нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгах саналыг 4 дүгээр сарын 5-ны дотор санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

3.3.4. санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь сангийн орлого, зарлагын жилийн төлөвлөгөөг хянан үзэж төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсвийн төсөлд тусгана.

3.4. Орон нутгийн төсвөөс халамжийн дэд санд олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулна.

3.5. Нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэх тусгай зориулалтын хэрэгслээр хангах үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэнэ.

Дөрөв. Сангийн зарцуулалт

4.1. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамжийн төвлөрсөн сангаас аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагад олгох санхүүжилтийн хуваарийг

улирал, сараар гаргаж нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн баталж Төрийн сангийн газарт хүргүүлнэ.

4.2. Төрийн сангийн газар нь төвлөрсөн төсвөөс олгох хөрөнгийг батлагдсан хуваарийн дагуу орон нутгийн төрийн сангийн тасаг дахь аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллагын дансанд улирал, сараар хуваарилан олгоно.

4.3. Орон нутгийн төрийн сангийн тасаг нь нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллагаас гаргасан хуваарийн дагуу арилжааны банкинд сар бүр хуваарилна.

4.4. Энэ дүрмийн 4.1-д заасан хуваарьт өөрчлөлт оруулах асуудлыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийн дагуу шийдвэрлэнэ.

4.5. Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд зориулан орон нутгийн төсвөөс нийгмийн халамжийн дэд санц олгох хөрөнгийг орон нутгийн төрийн сангийн тасаг улирал, сараар хуваарилж олгоно.

4.6. Нийгмийн халамжийн төвлөрсөн сангийн хөрөнгийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу тэтгэврийн болон Амьжиргааг дэмжих санд хуваарилан хууль, журамд заасан зориулалтын дагуу зарцуулна.

4.7. Сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно.

Тав. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, тайлан

5.1. Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийг тогтоосон хугацаанд олгох, хяналт тавих үүргийг аймаг,

дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.

5.2. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн хэмжээг тодорхойлох, хуваарилах, дотоод хяналт тавих үүргийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

5.3. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь сангийн төлөвлөлт, гүйцэтгэлийн байдалд хяналт-шинжилгээ хийж үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр сангийн жилийн төсвийн гүйцэтгэлийг батална.

5.4. Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтад Улсын мэргэжлийн хяналтын газар, Үндэсний аудитын газар эрх хэмжээний дотор тус тусын хяналт тавина.

5.5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зарлагын улирлын тайланг аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагын дарга тухайн улирлын дараа сарын 25-ны дотор, жилийн эцсийн нэгдсэн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус гаргаж ирүүлнэ.

5.6. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сангийн улирлын нэгдсэн тайланг дараа улирлын хоёр дахь сарын 20-ны дотор, жилийн эцсийн нэгдсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор тус тус гаргаж, санал дүгнэлтийн хамт нийгмийн халамжийн болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.7. Сангийн анхан шатны бүртгэл, тайлан тэнцэл, мэдээний маягын загвар, заавар, журмыг нийгмийн халамжийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Засгийн газрын 2006 оны 118 дугаар тогтоолын 2 дугаар хэвсрэлт

ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, НӨХЦӨЛТ МӨНГӨН ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн халамжийн тухай хуульд заасан халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг (цаашид "тэтгэвэр", "тэтгэмж" гэх) тогтоох, олгох, түүнийг зогсоохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Тэтгэвэр, тэтгэмжид хамрагдахыг хүссэн иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшинг Нийгмийн хамгаалал,

хөдөлмөрийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан тушаалаар баталсан "Өрхийн амьжиргааны түвшинг үнэлэх арга-члал"-ын дагуу сум, хорооны нийгмийн ажилтан үнэлж, Амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлнэ. Амьжиргааг дэмжих зөвлөлийн тодорхойлолтыг үндэслэн тэтгэвэр, тэтгэмж авах иргэдийн жагсаалтыг Засаг дарга батална.

1.3. Тэтгэвэр, тэтгэмжийг "нөн ядуу", "ядуу" гэсэн ангилалд багтсан өрхөд амьдарч байгаа

иргэнд олгоно. Халамжийн тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд энэ журмын 1.2-т заасан амьжиргааны түвшингийн үнэлгээ хийгдэхгүй бөгөөд харин тухайн иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг тогтоосон тухай эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр гарсан байна.

Хоёр. Тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах хүсэлтийг хянан шийдвэрлэх явц

2.1. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж авахыг хүссэн иргэн энэхүү журмын 6-д заасан материалыг бүрдүүлж сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө.

2.2. Сум, хорооны нийгмийн ажилтан тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргасан иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг гарган саналаа сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлд хүргүүлнэ.

2.3. Сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлж, тэтгэвэр, тэтгэмжид хамруулах эсэх тухай саналаа гаргаж сум, хорооны Засаг даргад уламжилна.

2.4. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамруулах асуудлыг сум, хорооны Засаг дарга Амьжиргааг дэмжих зөвлөлийн санал, тодорхойлолтыг үндэслэн ажлын 10 хоногт багтаан хянан шийдвэрлэж, тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалтыг батална.

2.5. Аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн ажилтан/ сум, хорооны Засаг даргын захирамжийг холбогдох материалын хамт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн дэвтрийг нээж өгнө.

2.6. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрах иргэнд олгох тэтгэмжийг асруулагчийн оршин суугаа аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага олгоно.

2.7. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрах иргэнд тэтгэмж олгоходоо тэтгэмж авах тухайн иргэн, асруулагч болон сум, хорооны нийгмийн ажилтны хооронд асрах талаар гурвалсан гэрээ байгуулсан байна.

Гурав. Тэтгэвэр, тэтгэмж олгох, үргэлжлэх хугацаа

3.1. Тэтгэвэрт хамрагдах хугацаа нь шийдвэр гарсан өдрөөс эхэлж хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, нас барах, амьжиргааны түвшин нь

дээшлэх болон хуулиар тогтоосон бусад эрх нь дуусгавар болох хүртэлх хугацаанд үргэлжилнэ.

3.2. Энэ журмын 3.1-д заасан хугацаа нь 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон иргэдийн хувьд нэгэн адил үйлчилнэ.

3.3. 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу жирэмсний болон амаржсаны, хүүхэд асарсны, нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж авах эрх үүссэн эхчүүдийн тэтгэмжийг анх хуулиар үүссэн эрх нь дуусах хүртэл хугацаанд үргэлжлүүлэн олгоно.

3.4. 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө Нийгмийн халамжийн тухай хуулиар жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн эхчүүдэд хүүхэд асарсны тэтгэмжийг үргэлжлүүлэн авах эрх нь нээлттэй байна.

3.5. Хүүхдээ 196-гаас доошгүй хоног тээгээд дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан эхэд тэтгэмжийг жирэмслэлтийг зогсоох хүртэл хугацаанд олгоно.

3.6. Ихэр хүүхэд төрсөн тохиолдолд тэтгэмжийн хэмжээг хүүхэд төрсөн сараас нь эхлэн 2 дахин нэмэгдүүлэн олгоно. Нэмэгдэл тэтгэмжийг хүүхдийг 1 нас хүртэлх хугацаанд олгоно.

3.7. Хэрэв гурав болон түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлсэн эх хүүхдүүдээ өөрөө асрах хүсэлтэй бол тэтгэмж олгох хугацааг 10 хүртэл сараар нэг удаа сунгана.

3.8. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрах иргэнд олгох тэтгэмжийн хугацааг хүсэлт гаргасан өдрөөс эхлэн тооцож эхний удаа 12 хүртэлх сараар тогтооно. Аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллагаас үнэлгээ хийсний үндсэн дээр Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналын дагуу уг тэтгэмжийг олгох хугацааг 10 хүртэл сараар нэг удаа сунгаж болно.

3.9. Сум, хорооны Засаг дарга халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан иргэдийн нэрсийн жагсаалтыг сум, хорооны нийт иргэдэд нээлттэй, ил тод мэдээлж байна.

Дөрөв. Тэтгэвэр, тэтгэмж олгох

4.1. Аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг банкаар дамжуулан сар бүр олгоно.

4.2. Иргэн байнга оршин сууж байгаа засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд бүрмөсөн шилжин

суурьшсанаас хойш 30 хоногийн дотор шилжин суурьшсан нутаг дэвсгэрийн захиргаанд бүртгүүлээгүй бол бүртгэлгүй байсан хугацааны тэтгэвэр, тэтгэмжийг нөхөн олгохгүй.

4.3. Сарын дундуур тэтгэвэр, тэтгэмж шинээр тогтоологх буюу хасагдах иргэний тэтгэвэр, тэтгэмжийг хуанлийн өдрөөр тооцож олгоно.

4.4. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж тэтгэвэр, тэтгэмжээ авах боломжгүй иргэний тэтгэвэр, тэтгэмжийг түүний итгэмжлэгдсэн хүнд, эсхүл нийгмийн халамжийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан гэрт нь хүргэж өгнө.

4.5. Арван зургаагаас доош насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох тэтгэврийг эцэг, эх, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгоно. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тухайн орон нутгийн шүүхээс тогтоосон байна.

4.6. Иргэн хүсэлтээ гаргасан тохиолдолд нийгмийн халамжийн байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг тухайн иргэний хадгаламжийн дансанд нь шилжүүлж болно.

4.7. Тухайн иргэн нь нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэмжийн зөвхөн нэг төрөлд хамрагдана. Хэрэв давхардахаар бол аль нэгийг нь иргэн өөрөө сонгон авах эрхтэй.

Тав. Тэтгэвэр, тэтгэмжийг зогсоох, суутгал хийх

5.1. Дараахь тохиолдолд халамж, үйлчилгээний байгууллага /сумын Засаг дарга/ иргэний тэтгэврийг зогсоох шийдвэр гаргана:

5.1.1. тухайн иргэний амьжиргааны түвшин дээшилсэн;

5.1.2. хууль ёсоор тэжээн тэтгүүлэх үндэс бүрдсэн;

5.1.3. хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжтой болсон;

5.1.4. хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн чадвар алдалт 70 хувиас бага болсон нь эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор тогтоогдсон;

5.1.5. өрх толгойлсон эх /эцэг/ бүхий өрхөд амьдарч байгаа хүүхэд 16 насанд хүрсэн;

5.1.6. тэтгэвэр авагч нь нас барсан;

5.1.7. тэтгэвэр авагч иргэн өөрийн хүсэлтээр тэтгэвэрээ зогсоож, амьжиргааг дэмжих тусламж авах хүсэлтээ гаргасан;

5.1.8. хуулиар тэтгэвэр авах хугацаа нь дуусгавар болсон.

5.2. Дараахь тохиолдолд сум, хорооны нийгмийн ажилтан жирэмсэн болон хөхүүл

хүүхэдтэй эхэд олгох тэтгэмжийг зогсоох тухай саналаа сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлд хүргүүлнэ:

5.2.1. өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн;

5.2.2. нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн;

5.2.3. хүүхэд нь нас барсан;

5.2.4. хугацаа нь дуусгавар болсон.

5.3. Дараахь тохиолдолд сум, хорооны нийгмийн ажилтан ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмжийг зогсоох тухай саналаа сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлд хүргүүлнэ:

5.3.1. ахмад настны биеийн эрүүл мэндийн байдал сайжирч эмч, эмнэлгийн байнгын хяналтаас гарсан;

5.3.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэний биеийн эрүүл мэндийн байдал сайжирч, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь буурсан тухай эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр гарч, эмчийн байнгын хяналт, байнгын асрамж шаардлагагүй болсон;

5.3.3. өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн;

5.3.4. асруулагч нас барсан.

5.4. Хуурамч бичиг баримт бүрдүүлж тэтгэвэр, тэтгэмж авсан нь тогтоогдвол тэтгэвэр, тэтгэмжийг зогсоож буруутай хуулийн этгээд, албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.

5.5. Илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг нөхөн төлүүлэх талаар шүүхийн, эсхүл улсын байцаагчийн шийдвэр гарсан бол тухайн иргэний сарын тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн 50-иас хэтрэхгүй хувиар суутгал хийж хохирлыг барагдуулна.

5.6 Энэ журмын 5.5-д зааснаас бусад тохиолдолд тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжээс суутгал хийхийг хориглоно.

Зургаа. Тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах иргэний бүрдүүлэх бичиг баримт.

6.1. Ахмад настан болон өрх толгойлсон олон хүүхэдтэй эх /эцэг/-д олгох тэтгэвэрт хамрагдахыг хүссэн иргэн дараахь бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө:

6.1.1. тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл;

6.1.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

6.1.3. нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үзэсгүүлийг гэрчилсэн тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /сумын нийгмийн даатгалын байцаагч/-ийн тодорхойлолт;

6.1.4. 0-16 хүртэл насны хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар;

6.1.5. өрхийн амьжиргааны мэдүүлэг /маягтаар/.

6.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тэтгэвэрт хамрагдахыг хүссэн иргэн дараахь бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө:

6.2.1. тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл;

6.2.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоосон эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын дүгнэлт;

6.2.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхийн хуулбар.

6.3. Жирэмсэн эмэгтэй болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхэд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжид хамрагдах хүсэлтэй эх дараахь бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө:

6.3.1. тэтгэмж тогтоолгон авахыг хүссэн өргөдөл;

6.3.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

6.3.3. жирэмсэн үедээ эмнэлгийн хяналтад орсон тухай сум, дүүргийн өрхийн эмнэлгийн тодорхойлолт;

6.3.4. нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын /сумын нийгмийн даатгалын байцаагч/ байгууллагын тодорхойлолт;

6.3.5. өрхийн амьжиргааны мэдүүлэг /маягтаар/.

6.4. Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрах иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжид хамрагдах хүсэлтэй иргэн дараахь бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө:

6.4.1. тэтгэмж авахыг хүссэн өргөдөл;

6.4.2. асруулагчийн иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

6.4.3. асрамжинд байх хүний талаархи эмнэлгийн байгууллагын дүгнэлт;

6.1.4. асруулагчийн өрхийн амьжиргааны мэдүүлэг /маягтаар/.

Долоо. Бусад

7.1. Тэтгэвэр, тэтгэмж тогтоох болон олгож байгаа байдал, тухайн жилд өрхийн амьжиргааны түвшинд гарсан өөрчлөлтөд аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллага сум, хорооны засаг захиргааны нэгжтэй хамтран жил бүр үнэлгээ хийнэ.

7.2. Иргэн шилжин суурьшсан тохиолдолд шилжин очсон нутаг дэвсгэрийнхээ захиргаа, иргэний бүртгэл, халамж, үйлчилгээний байгууллагад 30 хоногийн дотор бүртгүүлснээр тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах эрх үүснэ.

7.3. Сум, хорооны нийгмийн ажилтан нь орон нутгийн шилжилт хөдөлгөөнд хамрагдсан өрхийн мэдээ, тайланг сар бүр гарган аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлж байна.

7.4. Хуурамч бичиг баримт бүрдүүлж нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон иргэн болон хуурамч баримт үйлдсэн албан тушаалтан, нийгмийн ажилтанд Нийгмийн халамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэж, олгогдсон тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний зардлыг хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлнэ.

7.5. Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын алба хяналт тавьж ажиллана.

Засгийн газрын 2006 оны 118 дугаар тогтоолын 3 дугаар хэсэрлэлт

НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛЭГТ ХАМРАГДСАН ӨРХ, ИРГЭНД ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан иргэнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан хөнгөлөлт, тусламж олгох, халамжийн үйлчилгээг үзүүлэхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт, үйлчилгээний зардлыг Амьжиргааг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

Хоёр. Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх, иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламж, үйлчилгээний төрөл

2.1. Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх, иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламж дор дурдсан төрөлтэй байна:

2.1.1. амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж;

2.1.2. халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт;

2.1.3. сэргээн засах үйлчилгээний зардлын хөнгөлөлт.

2.2. Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх, иргэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээ нь дор дурдсан төрөлтэй байна:

2.2.1. амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

2.2.2. зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад нь туслах, энэ чиглэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөрт зуучлан хамруулах;

2.2.3. сэргээн засах үйлчилгээнд хамруулах;

2.2.4. түр байрлуулан асрамжлах;

2.2.5. гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах.

Гурав. Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх, иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжийн хамрах хүрээ, хэмжээ, зохицуулалт

3.1. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид дор дурдсан иргэн хамрагдана:

3.1.1. 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө тогтоогдсон нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрх нь дуусгавар болсон хөгжлийн бэрхшээлтэй иргэн /хөдөлмөрийн чадвар алдалт нь 70 хувиас доогуур тогтоогдсон/;

3.1.2. нийгмийн халамжийн тэтгэврийг 1-ээс дээш жил авах эрхтэй боловч сайн дураараа энэ журамд заасан тусламжид хамрагдах зорилгоор нийгмийн халамжийн тэтгэврээ зогсоолгох хүсэлт гаргасан иргэн.

3.2. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийг олгоход:

3.2.1. иргэн халамжийн тэтгэврээ зогсоолгох, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдах тухай хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажиглалтанд гаргана;

3.2.2. сум, хорооны нийгмийн ажиглалт мөнгөн тусламжид хамрагдах хүсэлтээ гаргасан иргэнтэй хамтран өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулна. Өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд тухайн иргэн, түүний амьдарч байгаа өрхийн амьжиргааг дээшлүүлэх боломж, чиглэл, үйл ажиллагаа, хүрэх үр дүн, хугацааг нарийвчлан тодорхойлсон байна;

3.2.3. сум, хорооны нийгмийн ажиглалт нь өрхийн хөгжлийн төлөвлөгөөг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлд хүргүүлнэ;

3.2.4. сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл мөнгөн тусламжид хамруулах эсэх тухай саналаа сум, хорооны Засаг даргад уламжилна;

3.2.5. мөнгөн тусламжид хамруулах асуудлыг сум, хорооны Засаг дарга Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн ажлын 10 хоногт багтаан хянан шийдвэрлэж, тусламжид хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалтыг батална;

3.2.6. аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн ажиглалт/ сум, хорооны Засаг даргын захирамжийг үндэслэн өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хянан үзэж, тусламж олгох асуудлыг шийдвэрлэнэ;

3.2.7. аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллагын шийдвэрт үндэслэн тухайн иргэний оршин суугаа сум, хорооны Засаг дарга, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийг авах эрх бүхий иргэнтэй гэрээ байгуулж аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллагаар батлуулна;

3.2.8. аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллага гэрээнд заасан нөхцөлийн дагуу мөнгөн тэтгэмжийг тухайн иргэнд банкаар дамжуулан олгоно;

3.2.9. энэ журмын 3.2.7-д заасан мөнгөн тусламжийг олгох гэрээний үлгэрчилсэн загварыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

3.3. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор тэднийг мэргэжил олгох сургалтад хамруулах, ажлын байр болон жижиг эзэлд зуучлах ажлыг сум, хорооны нийгмийн ажиглалт өрхийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулна.

3.4. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийн хэмжээ нь тухайн иргэний нэг жилд авах нийгмийн халамжийн тэтгэврийн нийт дүнгээс илүүгүй байна.

3.5. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсанаар тухайн иргэний нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдах эрх нь дуусгавар болно.

3.6. Халамжийн цэцэрлэгийн хоолны үнийн хөнгөлөлтөд 6 хүртэлх насны дор дурдсан хүүхэд хамрагдана:

3.6.1. хөгжлийн бэрхшээлтэй иргэний;

3.6.2. ядуу амьдралтай бүтэн болон хагас өнчин;

3.6.3. хөгжлийн бэрхшээлтэй;

3.6.4. нэн ядуу амьдралтай өрхийн.

3.7. Халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт олгоход;

3.7.1. хөнгөлөлтөд хамрагдахыг хүссэн иргэн дараахь бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө;

-өргөдөл;

-эцэг, эх /эсвэл асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

-өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээ /маягтаар/;

-хүүхдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;

-цэцэрлэгт хүмүүждэг тухай тодорхойлолт.

3.7.2. сум, хорооны нийгмийн ажилтан хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт гаргасан иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг гарган саналаа сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлд хүргүүлнэ;

3.7.3. сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлж, хөнгөлөлтөд хамруулах эсэх тухай саналаа сум, хорооны Засаг даргад уламжилна;

3.7.4. хөнгөлөлтөд хамруулах асуудлыг сум, хорооны Засаг дарга Амьжиргааг дэмжих зөвлөлийн санал, тодорхойлолтыг үндэслэн ажлын 10 хоногт багтаан хянан шийдвэрлэж, мөнгөн тусламжид хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалтыг батална;

3.7.5. аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн ажилтан/ цэцэрлэгийн үнийн хөнгөлөлтийг банкаар дамжуулан сургуулийн өмнөх байгууллагад улирал бүр шилжүүлнэ.

Дөрөв. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хамрах хүрээ, зохицуулалт

4.1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд нэн ядуу амьдралтай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хүчирхийлэлд өртсөн иргэн, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж нь зогсоогдсон эмзэг бүлгийн иргэн хамрагдана.

4.2. Энэ журмын 4.1-д заасан иргэнд дараахь үйлчилгээг үзүүлнэ:

4.2.1. зөвлөгөө өгөх;

4.2.2. мэргэжлийн сургалтад хамруулах;

4.2.3. орлого нэмэгдүүлэх төсөл, зээл, ажлын байранд зуучлах;

4.2.4. сэргээн засах;

4.2.5. түр байранд байрлуулах;

4.2.6. гэрийн нөхцөлд асрамжлах.

4.3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэхэд

4.3.1. энэ журмын 4.1-д заасан иргэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд гаргана;

4.3.2. сум, хорооны нийгмийн ажилтан нь үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан эмзэг бүлгийн өрх, иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг гаргаж нэн тэргүүний хэрэгцээ бүхий 3-аас дээшгүй үйлчилгээний төрлийг сонгож, саналын хамт сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлд хүргүүлнэ.

4.3.3. сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл нийгмийн ажилтны саналыг хянан хэлэлцэж, өрхийн амьжиргааны түвшин, үйлчилгээнд хамруулах эсэх тухай тодорхойлолт гаргаж сум, хорооны Засаг даргад уламжилна.

4.3.4. үйлчилгээнд хамруулах асуудлыг сум, хорооны Засаг дарга Амьжиргааг дэмжих зөвлөлийн санал, тодорхойлолтыг үндэслэн ажлын 10 хоногт багтаан хянан шийдвэрлэж, үйлчилгээнд хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалтыг батална;

4.3.5. аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага нэн тэргүүний хэрэгцээт үйлчилгээний төрөл, хамрагдах өрх, иргэдийн тоо, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлж, үйлчилгээг холбогдох мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

4.4. Ижил төрлийн хэрэгцээ бүхий эмзэг бүлгийн иргэдийг өөрсдийн саналцаарь нь бүлгийн зохион байгуулалтад оруулах, сургалтад хамруулах ажлыг үйлчилгээ үзүүлэгч мэргэжлийн байгууллага, тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргаа, аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага хамтран гүйцэтгэнэ.

Тав. Бусад

5.1. Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн халамжийн асуудал харуцсан төрийн захиргааны байгууллага жил тутам үнэлгээ өгнө.

5.2. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэнд хувийн хэрэг нээн /суманд нийгмийн ажилтан, дүүрэгт нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага/ тухай бүр бичилт хийж хяналт тавина.

5.3. Сум, хороодын Амьжиргааг дэмжих зөвлөл, нийгмийн ажилтан энэ журамд заасан үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийн ядуу, нэн ядуу болохыг Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.3-т заасан аргачлалын дагуу үнэн зөв тодорхойлж гаргах үүрэгтэй.



5.4. Энэ журамд заасан бичиг, баримтыг хуурамчаар үйлдсэн иргэн болон халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэнийг буруу тогтоосон, тодорхойлолтыг үндэслэлгүй буюу хуурамчаар үйлдсэн, амьжиргааг дэмжих сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, эсхүл хувийн зорилгод ашиглах зэргээр хууль зөрчсөн албан тушаалтан, нийгмийн ажилтанд Нийгмийн

халамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэж олгогдсон тусламж, үйлчилгээний зардлыг хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлнэ.

5.5. Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга хяналт тавьж ажиллана.

Засгийн газрын 2006 оны 118 дугаар тогтоолын 4 дүгээр хэвсрэлт

АХМАД НАСТАНД ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ахмад настанд Нийгмийн халамжийн тухай хуулийн 25 дугаар зүйл, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан тусламж, хөнгөлөлтийг олгоход энэхүү журмыг баримтална.

Хоёр. Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт

2.1. Ахмад настанд дотоодод хийлгэсэн /сүүж, түнх, дунд чөмөг, шилбэ, өвдөг, тавхай, тавхайн урд хэсэг, мөр, шуу, сарвуу, буйл, шүд, эрүү, шилэн болон хуванцар нүд, нүдний болор/ протезийн үнийг нэг удаа нөхөн олгоно.

2.2. Ахмад настанд харах болон сонсох эрхтэний ортопедийн хэрэгсэл /сонсголын аппарат, харааны шил/-ийг нэг удаа үнэ төлбөргүй олгоно.

2.3. Дотоодод хийлгэсэн протез, ортопедийн хэрэгслийн зардлыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг үнээр тооцож Амьжиргааг дэмжих сангаас энэ журмын 5.1-д заасан бичиг баримтыг үндэслэн банкны байгууллагаар дамжуулан нэг удаа нөхөн олгоно.

2.4. Ахмадын зориулалттай амралт, рашаан сувиллын эрхийн бичгийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан хөнгөлөлттэй үнээр олгоно.

2.5. Авто тээврийн тухай хуулийн 12.2-т заасан нөхөн олговор олгох журмыг тухайн аймаг болон нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэсэн тохиолдолд ахмад настан нь нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл (таксинаас бусад)-ээр үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр зорчино.

Гурав. Нэн ядуу амьдралтай ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт

3.1. Нэн ядуу амьдралтай ахмад настны амьдарч байгаа орон сууцны халаалт, ус ашигласны

төлбөр төлөх; түлээ, нүүрс худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газраас тогтоосон хэмжээний мөнгөн тусламжийг жилд нэг удаа олгоно. Энэхүү мөнгөн тусламжийг олгоход:

3.1.1. мөнгөн тусламжид хамрагдахыг хүссэн ахмад настан хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд энэ журмын 5.2-т заасан бичиг баримтын хамт бүрдүүлэн өгнө;

3.1.2. сум, хорооны нийгмийн ажилтан мөнгөн тусламжид хамрагдах хүсэлт гаргасан иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг гарган саналаа сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлд хүргүүлнэ;

3.1.3. сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлж, мөнгөн тусламжид хамруулах эсэх тухай саналаа сум, хорооны Засаг даргад уламжилна;

3.1.4. мөнгөн тусламжид хамруулах асуудлыг сум, хорооны Засаг дарга Амьжиргааг дэмжих зөвлөлийн санал, тодорхойлолтыг үндэслэн ажлын 10 хоногт багтаан хянан шийдвэрлэж, мөнгөн тусламжид хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалтыг батална;

3.1.5. аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн ажилтан/ сум, хорооны Засаг даргын захирамж, холбогдох материалыг үндэслэн мөнгөн тусламжийг тухайн ахмад настанд банкаар дамжуулан олгоно.

3.2. Нэн ядуу амьдралтай ахмад настан эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд сувилуулахыг хүсвэл тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгоно. Энэхүү хөнгөлөлтийг олгоход:

3.2.1. дотоодын рашаан сувилалд сувилуулахыг хүссэн нэн ядуу амьдралтай ахмад настан хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд энэ журмын 5.3-т заасан бичиг баримтын хамт бүрдүүлэн өгнө.

3.2.2. сум, хорооны нийгмийн ажилтан хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт гаргасан иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг гарган саналаа сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлд хүргүүлнэ;

3.2.3. сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлж хөнгөлөлтөд хамруулах эсэх тухай саналаа сум, хорооны Засаг даргад уламжилна;

3.2.4. хөнгөлөлтөд хамруулах асуудлыг сум, хорооны Засаг дарга Амьжиргааг дэмжих зөвлөлийн санал, тодорхойлолтыг үндэслэн ажлын 10 хоногт багтаан хянан шийдвэрлэж, хөнгөлөлтөд хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалтыг батална;

3.2.5. хөнгөлөлтийг аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага / суманд нийгмийн ажилтан/ сум, хорооны Засаг даргын захирамж, холбогдох материалыг үндэслэн тухайн ахмад настанд банкаар дамжуулан нөхөн олгоно.

3.3. Дотоодын рашаан, сувилалд амрахыг хүссэн хүндэт донор ахмад настан хүсэлтээ Монголын донорын холбоо /аймагт Улаан загалмайн хороо/-нд энэ журмын 5.4-т заасан бичиг баримтын хамт бүрдүүлж өгнө. Энэхүү хөнгөлөлтийг олгоход:

3.3.1. Монголын донорын холбоо / аймагт Улаан загалмайн хороо/ рашаан, сувилалд амрах ахмад настан хүндэт донорын нэрсийн жагсаалтыг холбогдох бичиг баримтын хамт бүрдүүлж аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагад хүргүүлнэ;

3.3.2. аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага тухайн ахмад настан хүндэт донорт рашаан, сувиллын зардлын хөнгөлөлтийг банкаар дамжуулан нөхөн олгоно.

3.4. Нийгмийн даатгалын талаархи хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, нэн ядуу амьдралтай, ганц бие ахмад настны оршуулгад зориулан нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувьтай тэнцэх хэмжээний тусламжийг энэ журмын 5.5-д заасан бичиг баримтыг үндэслэн сум, хорооны Засаг даргын томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгчид банкны байгууллагаар дамжуулан олгоно.

Дорov, Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт

4.1. Монгол Улсын болон Хөдөлмөрийн баатар, ардын цолтон, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн, улсын бэрүүн хил дээр 1940–1948 онд болсон зэвсэгт тулгаралтад оролцсон ахмад дайчин, дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр /нөхөр/-т дараахь тусламж, хөнгөлөлтийг энэ журмын 5.6-5.9-д заасан бичиг

баримтыг үндэслэн аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага банкаар дамжуулан олгоно:

4.1.1. Засгийн газраас тогтоосон хэмжээний мөнгөн тусламжийг улирал бүр;

4.1.2. нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардлыг жилд нэг удаа;

4.1.3. магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд ирэх, буцах замын зардал, эрхийн бичгийн үнийг жилд нэг удаа нөхөн олгох;

4.1.4. орон сууцны халаалт, ус ашигласны төлбөр төлөх болон түлээ, нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газраас тогтоосон хэмжээний мөнгөн тусламжийг жилд нэг удаа олгоно. Тусламжийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон нийтлэг жишгийг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэнэ.

4.2. Монгол Улсын гавьяат, Төрийн соёрхолт, Улсын ударник цолтон, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн ахмад настанд дараахь тусламж, хөнгөлөлтийг энэ журмын 5.6-5.9-д заасан бичиг баримтыг үндэслэн аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага банкаар дамжуулан олгоно:

4.2.1. Засгийн газраас тогтоосон хэмжээний мөнгөн тусламжийг жилд нэг удаа;

4.2.2. нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардлыг жилд нэг удаа;

4.2.3. магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд ирэх, буцах замын зардал, эрхийн бичгийн үнийг жилд нэг удаа нөхөн олгох;

4.2.4. орон сууцны халаалт, ус ашигласны төлбөр төлөх; түлээ, нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газраас тогтоосон хэмжээний мөнгөн тусламжийг жилд нэг удаа олгоно.

4.3. "Алдарт эх" I, II, Подонтой ахмад настанд Засгийн газраас тогтоосон хэмжээний мөнгөн тусламжийг энэ журмын 5.6.1, 5.6.2-т заасан бичиг баримтыг үндэслэн аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллага жилд нэг удаа олгоно.

4.4. Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийн дагуу 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө хөнгөлөлт эдлэх эрх үүссэн төрийн өндөр албан тушаал хашиж байсан ахмад настанд орон сууцны халаалт, ус ашигласны төлбөр төлөх, түлээ, нүүрс худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газраас тогтоосон хэмжээний мөнгөн тусламжийг энэ журмын 5.10-т заасан бичиг баримтыг үндэслэн аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллага жилд нэг удаа олгоно.

Тав. Бүрдүүлэх бичиг баримт

5.1. Дотоодод хийлгэсэн протез, ортопедийн хэрэгслийн зардлыг нөхөн авахад бүрдүүлэх бичиг баримт:

5.1.1. өргөдөл;

5.1.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.1.3. сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

5.1.4. протез, ортопедийн хэрэгсэл хийлгэсэн тухай баримт.

5.2. Нэн ядуу амьдралтай ахмад настны орон сууцны халаалт, ус ашигласны төлбөр төлөх; түлээ, нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх мөнгөн тусламж авахад бүрдүүлэх бичиг баримт:

5.2.1. өргөдөл;

5.2.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.2.3. өрхийн амьжиргааны мэдүүлэг/ маягтаар/.

5.3. Дотоодын рашаан сувиллын зардлын хөнгөлөлт эдлэх нэн ядуу ахмад настны бүрдүүлэх бичиг баримт:

5.3.1. өргөдөл;

5.3.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.3.3. унааны хөлс төлсөн баримт;

5.3.4. эрхийн бичиг;

5.3.5. эмнэлгийн байгууллагын дүгнэлт;

5.3.6. өрхийн амьжиргааны мэдүүлэг.

5.4. Дотоодын рашаан сувиллын зардлын хөнгөлөлт эдлэх хүндэт донор ахмад настны бүрдүүлэх бичиг баримт:

5.4.1. өргөдөл;

5.4.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.4.3. унааны хөлс төлсөн баримт;

5.4.4. эрхийн бичиг;

5.4.5. Монголын донорын холбооны үнэмлэх, хуулбарын хамт /нийслэлд/;

5.4.6. Улаан загалмайн хорооны үнэмлэх, хуулбарын хамт /аймагт/.

5.5. Нэн ядуу, ганц бие ахмад настны оршуулгад зориулж зардал олгоход бүрдүүлэх бичиг баримт:

5.5.1. нас барсны гэрчилгээ;

5.5.2. оршуулгын тэтгэмж олгоогүй

тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын /суманд

нийгмийн даатгалын байцаагч/ байгууллагын тодорхойлолт;

5.5.3. нэн ядуу, ганц бие болохыг

нотолсон сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

5.5.4. итгэмжлэгчийг томилсон

тухай сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

5.5.5. итгэмжлэгдсэн этгээдийн

иргэний үнэмлэх, хуулбарын хамт.

5.6. Энэхүү журмын 4.1, 4.2, 4.3-т заасан ахмад настанд Засгийн газраас тогтоосон хэмжээний мөнгөн тусламжийг олгоход бүрдүүлэх бичиг баримт:

5.6.1. өргөдөл;

5.6.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.6.3. алдар цолны үнэмлэх, хуулбарын хамт;

5.6.4. ахмад дайчны үнэмлэх, хуулбарын хамт.

5.7. Энэхүү журмын 4.1, 4.2-т заасан ахмад настанд нийслэлээс аймаг, аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардал олгоход бүрдүүлэх бичиг баримт:

5.7.1. өргөдөл;

5.7.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.7.3. алдар цолны үнэмлэх, хуулбарын хамт;

5.7.4. ахмад дайчны үнэмлэх, хуулбарын хамт;

5.7.5. унааны хөлс төлсөн баримт.

5.8. Энэхүү журмын 4.1, 4.2-т заасан ахмад настанд дотоодын рашаан сувилалд ирэх, буцах замын зардал, эрхийн бичгийн үнийг нөхөн олгоход бүрдүүлэх бичиг баримт:

5.8.1. өргөдөл;

5.8.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.8.3. алдар цолны үнэмлэх, хуулбарын хамт;

5.8.4. ахмад дайчны үнэмлэх, хуулбарын хамт

5.8.5. унааны хөлс төлсөн баримт;

5.8.6. эрхийн бичиг.

5.9. Энэхүү журмын 4.1, 4.2-т заасан ахмад настанд орон сууцны халаалт, ус ашигласны төлбөр төлөх; түлээ, нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх тусламж олгоход бүрдүүлэх бичиг баримт:

5.9.1. өргөдөл;

5.9.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.9.3. алдар цолны үнэмлэх, хуулбарын хамт;

5.9.4. ахмад дайчны үнэмлэх, хуулбарын хамт.

5.10. 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө эрх нь үүссэн төрийн өндөр албан тушаал хашиж байсан ахмад настны орон сууцны халаалт, ус ашигласны төлбөр төлөх; түлээ, нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх тусламжид хамруулахад бүрдүүлэх бичиг баримт:

5.10.1. өргөдөл;

5.10.2. иргэний үнэмлэх,

хуулбарын хамт;

5.10.3. төрийн өндөр албан тушаал хашиж байсныг гэрчлэх бичиг баримт, хуулбарын хамт.

Зургаа. Бусад

6.1. Ахмад настанд тусламж, хөнгөлөлт олгох үйл ажиллагааг аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

6.2. Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ахмад настны нийтлэг эрх ашгийг төлөөлж чадах төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

6.3. Ахмад настанд тусламж, хөнгөлөлтийн зардлыг урьдчилан олгохгүй.

6.4. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд заасан хоёр буюу түүнээс дээш төрлийн алдар цолтой ахмад настан зөвхөн нэг төрлийн алдар цолныхоо дагуу тусламж, хөнгөлөлтөд хамрагдана.

6.5. Аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллага холбогдох шийдвэр, бичиг баримтыг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор тусламж, хөнгөлөлт олгох эсэх асуудлыг хянан шийдвэрлэнэ.

6.6. Аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллага тусламж, хөнгөлөлтөд хамрагдсан ахмад настанд хувийн хэрэг нээж тухай бүр бичилт хийж, хяналт тавина.

6.7. Энэхүү журамд заасан бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн иргэн, тусламж, хөнгөлөлтөд хамрагдах иргэнийг буруу тогтоосон, тодорхойлолтыг үндэслэлгүй буюу хуурамчаар үйлдсэн албан тушаалтан, нийгмийн ажилтанд Нийгмийн халамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэж олгогдсон тусламж, хөнгөлөлтийн зардлыг хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлнэ.

6.8. Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга хяналт тавьж ажиллана.

Засгийн газрын 2006 оны 118 дугаар тогтоолын 5 дугаар хэсгэрлэлт

ХОГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 25 дугаар зүйл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1-д заасан тусламж, хөнгөлөлтийг үзүүлэхэд энэхүү журмыг баримтална.

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох протез, ортопедийн төрөл

2.1. Протез, ортопедийн болон тусгай хэрэгсэлд дараахь зүйлсийг хамруулна:

2.1.1. протез: нүдний болор, шилэн болон хуванцар нүд, эрүү, мөр, бугалга, тохой, шуу, сарвуу, гарын хуруу, сүүж, түнх, дунд чөмөг, өвдөг, шилбэ, тавхай, тавхайн урд хэсэг;

2.1.2. ертсепедийн хэрэгсэл: согор засах бүх төрлийн гутал, нурууны хамгаалалт, төрөл бүрийн чиг, хараагүй хүний таяг болон бусад

төрөл бүрийн таяг, хүзүүвч, павликийн дөрөөвч, алхуулагч, төрөл бүрийн улавч;

2.1.3. тусгай хэрэгсэл: тэргэнцэр, сонсголын аппарат, хараагүй хүний брайлийн хэрэгсэл, бичиг томруулагч линзэн шил, магнитофон, радио хүлээн авагч, (+5, -5) ба түүнээс дээш нэмэх, хасах хараатай нүдний шил.

Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт, зохицуулалт

3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дор дурдсан хөнгөлөлт үзүүлнэ:

3.1.1. хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн ажилтан/ банкаар дамжуулан 100 хувь нөхөн олгоно.

3.1.2. энэ журмын 3.1.1-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эхний удаа хийлгэсэн протез нь хугацаа, эдлэлгээний хүчин зүйлийн улмаас шаардлага хангахгүй болсон тохиолдолд протезийн үнийг хоёр дахь удаа 100 хувь нөхөн олгоно.

3.1.3. нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн ажилтан/ банкаар дамжуулан 100 хувь нөхөн олгоно.

3.1.4. Энэ журмын 3.1.3-т заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэний эхний удаа хийлгэсэн протез нь хугацаа, эдлэлгээний хүчин зүйлийн улмаас шаардлага хангахгүй болсон тохиолдолд протезийн үнийг хоёр дахь удаа 50 хувь нөхөн олгоно.

3.2. Ядуу амьдралтай өрхийн хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхэд, түүнчлэн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх үүсээгүй, ядуу амьдралтай өрхийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүний дотоодод хийлгэсэн ортопедийн болон тусгай хэрэгслийн үнийг аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн ажилтан/ банкаар дамжуулан нэг удаа 100 хувь нөхөн олгоно. Энэхүү хөнгөлөлтийг олгоход:

3.2.1. хөнгөлөлтөд хамрагдахыг хүссэн иргэн хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд энэ журамд заасан бичиг баримтын хамт бүрдүүлэн өгнө;

3.2.2. сум, хорооны нийгмийн ажилтан хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт гаргасан иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг гарган саналаа сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлд хүргүүлнэ;

3.2.3. сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлж, хөнгөлөлтөд хамруулах эсэх тухай саналаа сум, хорооны Засаг даргад уламжилна;

3.2.4. хөнгөлөлтөд хамруулах асуудлыг сум, хорооны Засаг дарга Амьжиргааг дэмжих зөвлөлийн санал, тодорхойлолтыг үндэслэн ажлын 10 хоногт багтаан хянан шийдвэрлэж, хөнгөлөлтөд хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалтыг батална;

3.2.5. аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн ажилтан/ сум, хорооны Засаг даргын захирамж, холбогдох материалыг үндэслэн хөнгөлөлтийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд банкаар дамжуулан олгоно.

3.3. Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жишиг үнийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.4. Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийг гадаадад хийлгэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөнгөлөлт үзүүлэхдээ дотоодод хийлгэсэн протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жишиг үнээр тооцож олгоно.

Дорov. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлэх тусламж, хөнгөлөлт, зохицуулалт

4.1. Харах, сонсох, ярих боломж нь хязгаарлагдмал сурагч болон түүний асран хамгаалагч эсхүл харгалзан дэмжигч нэг хүний хамт тусгай суруульд суралцахаар ирсэн тохиолдолд ирэх болон буцах унааны зардлыг аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн ажилтан/ жилд нэг удаа банкаар дамжуулан нөхөн олгоно.

4.2. Нэн ядуу амьдралтай өрхийн хараагүй, хэлгүй, дулий, одой болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний 4 хүртэлх насны нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны төлбөрийн 50 хувийг олгоно.

4.3. Ядуу амьдралтай, хөдөлмөрийн чадвартай гишүүнгүй, насанд хүрсэн бүрэн хараагүй иргэнтэй өрхийн суурин телефон утас ашигласны төлбөрт зориулж Засгийн газраас тогтоосон хэмжээний хөнгөлөлт үзүүлнэ.

4.4. Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, нэн ядуу амьдралтай өрхөд эзэмшиж байгаа орон сууцны халаалт, ус ашигласны төлбөр төлөх, түлээ нүүрс худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газраас тогтоосон хэмжээний мөнгөн тусламжийг жилд нэг удаа олгоно.

4.5. Хэрэв нэн ядуу өрхөд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хоёр болон түүнээс дээш тооны иргэн амьдарч байгаа бол энэ журмын 4.4-т заасан мөнгөн тусламжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэн олгоно.

4.6. Нэн ядуу амьдралтай өрхөд амьдарч байгаа хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүн эх орны рашаан сувилалд сувилуулсан тохиолдолд эрхийн бичгийн үнийн 50 хувийг нөхөн олгоно.

4.7. Энэ журмын 4.2, 4.3, 4.4, 4.6-д заасан тусламж, хөнгөлөлтийг олгоход:

4.7.1. тусламж, хөнгөлөлтөд хамрагдахыг хүссэн иргэн хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд энэ журамд заасан холбогдох бичиг баримтын хамт бүрдүүлэн өгнө;

4.7.2. сум, хорооны нийгмийн ажилтан тусламж, хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт гаргасан иргэний амьдарч байгаа өрхийн

амьжиргааны түвшингийн үнэлгээг гарган саналаа сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлд хүргүүлнэ;

4.7.3. сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл иргэний амьдарч байгаа өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлж, тусламж, хөнгөлөлтөд хамруулах эсэх тухай саналаа сум, хорооны Засаг даргад уламжилна;

4.7.4. хөнгөлөлт, тусламжид хамруулах асуудлыг сум, хорооны Засаг дарга Амьжиргааг дэмжих зөвлөлийн санал, тодорхойлолтыг үндэслэн ажлын 10 хоногт багтаан хянан шийдвэрлэж, тусламж, хөнгөлөлтөд хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалтыг батална;

4.7.5. аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн ажилтан/ сум, хорооны Засаг даргын захирамж, холбогдох материалыг үндэслэн тусламж, хөнгөлөлтийг тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд банкаар дамжуулан олгоно.

Тав. Тусламж, хөнгөлөлтөд хамрагдах бүрдүүлэх бичиг баримт

5.1. Энэ журмын 3.1.1-д заасан протезийн үнийн хөнгөлөлтийг дор дурдсан бичиг баримтыг үндэслэн олгоно:

5.1.1. протезийн үнийг нөхөн авахыг хүссэн тухай өргөдөл;

5.1.2. төрсний гэрчилгээ /16 насанд хүрсэн бол иргэний үнэмлэх/, хуулбарын хамт;

5.1.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.1.4. протезийн үнийн нэхэмжлэл, эсхүл мөнгө төлсөн тухай санхүүгийн баримт.

5.2. Энэ журмын 3.1.3-т заасан протезийн үнийн хөнгөлөлтийг дор дурдсан бичиг, баримтыг үндэслэн олгоно:

5.2.1. протезийн үнийг нөхөн авахыг хүссэн тухай өргөдөл;

5.2.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.2.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.2.4. протезийн үнийн нэхэмжлэл, эсхүл мөнгө төлсөн тухай санхүүгийн баримт;

5.2.5. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, ортопедийн хэрэгслийн төлбөр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын /сумын нийгмийн даатгалын байцаагч/ байгууллагын тодорхойлолт.

5.3. Энэ журмын 3.2-т заасан ортопедийн болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг дор дурдсан бичиг баримтыг үндэслэн олгоно:

5.3.1. ортопед, тусгай хэрэгслийн үнийг нөхөн авахыг хүссэн тухай өргөдөл;

5.3.2. төрсний гэрчилгээ /16 насанд хүрсэн бол иргэний үнэмлэх/, хуулбарын хамт;

5.3.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт.

5.3.4. ортопед, тусгай хэрэгслийн үнийн нэхэмжлэл, эсхүл мөнгө төлсөн тухай санхүүгийн баримт;

5.3.5. өрхийн амьжиргааны мэдүүлэг /маягтаар/;

5.3.6. 18 наснаас дээш настай тохиолдолд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлбөр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын /суманд нийгмийн даатгалын байцаагч/ байгууллагын тодорхойлолт.

5.4. Энэ журмын 4.1-д заасан тусламжийг авах иргэн дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлж аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллагад өгнө:

5.4.1. сум, хорооны Засаг даргаар баталгаажуулсан өргөдөл;

5.4.2. төрсний гэрчилгээ /16 насанд хүрсэн бол иргэний үнэмлэх/, хуулбарын хамт;

5.4.3. асран хамгаалагч буюу харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.4.4. хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.4.5. тухайн орон нутгийн тарифт үнээр тооцож замын зардал төлсөн тухай баримт, эсхүл нэхэмжлэл;

5.4.6. сургуулийн тодорхойлолт.

5.5. Энэ журмын 4.2-т заасан хөнгөлөлтийг авахыг хүссэн иргэн дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө:

5.5.1. өргөдөл;

5.5.2. аймаг, дүүргийн эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр;

5.5.3. хүүхдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;

5.5.4. хүүхэд нь цэцэрлэгт хүмүүждэг тухай тодорхойлолт.

5.6. Энэ журмын 4.3, 4.4-т заасан тусламжийг дор дурдсан бичиг баримтыг үндэслэн олгоно:

5.6.1. өргөдөл;

5.6.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт.

5.6.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

5.6.4. аймаг, дүүргийн эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр.

5.7. Энэ журмын 4.6-д заасан хөнгөлөлтийг дор дурдсан бичиг баримтыг үндэслэн олгоно:

5.7.1. өргөдөл;

5.7.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт.

5.7.3. аймаг, дүүргийн эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр;

5.7.4. эрхийн бичгийн үнэ төлсөн тухай санхүүгийн баримт эсхүл нэхэмжлэл;

Зургаа. Бусад

6.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт олгох ажлыг аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн ажилтан/ эрхлэн гүйцэтгэнэ.

6.2. Аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага /суманд нийгмийн

ажилтан/ холбогдох баримт, материалыг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор тусламж, хөнгөлөлт олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

6.3. Аймаг, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллага тусламж, хөнгөлөлтөд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хувийн хэрэг нээн тухай бүр бичилт хийж, хяналт тавина.

6.4. Энэхүү журамд заасан бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн иргэн болон тусламж, хөнгөлөлтөд хамрагдах иргэнийг буруу тогтоосон, тодорхойлолтыг үндэслэлгүй буюу хуурамчаар үйлдсэн албан тушаалтан, нийгмийн ажилтанд Нийгмийн халамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэж олгогдсон тусламж, үйлчилгээний зардлыг хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлнэ.

6.5. Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга хяналт тавьж ажиллана.

Засгийн газрын 2006 оны 118 дугаар тогтоолын 6 дугаар хэсэрлэлт

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАНД НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу тусгай хэрэгцээт боловсрол олгох төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан сургалтын байгууллагын инженер-техникийн болон үйлчилгээний ажилтан, арга зүйч, багш, сурган хүмүүжүүлэгчид нэмэгдэл хөлс олгоход энэхүү журмыг баримтална.

Хоёр. Нэмэгдэл хөлсний хэмжээ

2.1. Энэ журмын 1.1-д заасан албан хаагчийн албан тушаалын үндсэн цалинг төрийн үйлчилгээний ижил төрлийн албан тушаалын албан хаагчийн цалингийн сүлжээг баримтлан тогтооно.

2.2. Тусгай хэрэгцээт боловсрол олгох төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан сургалтын байгууллагын албан хаагчдад ажлын нөхцөлийг нь харгалзан албан тушаалын цалингаас дор дурдсан хувиар бодож нэмэгдэл хөлс олгоно:

2.2.1. арга зүйч, багш, сурган хүмүүжүүлэгч, дотуур байрны хүмүүжүүлэгчид албан тушаалын цалингийн 30 хүртэл хувиар;

2.2.2. сургалтын үйл ажиллагааг шууд гардан хариуцаж зохион байгуулдаг инженер-техникийн болон үйлчилгээний албан хаагчдад албан тушаалын цалингийн 20 хүртэл хувиар;

2.2.3. захиргааны гүйцэтгэх болон үйлчилгээний албан хаагчдад албан тушаалын цалингийн 10 хүртэл хувиар.

Гурав. Бусад

3.1. Нэмэгдэл хөлсний хэмжээг тусгай хэрэгцээт боловсрол олгох төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан сургалтын байгууллагын албан хаагчийн ажлын ачаалал, үр дүн, тухайн сургалтын байгууллагад ажилласан хугацааг харгалзан тухайн ажилтан, албан хаагчийн сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн тушаалаар тус тус олгоно. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын албан хаагчийн ажлын ачаалал, үр дүнг тооцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.2. Нэмэгдэл хөлсийг зөвхөн тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагад тухайн албан тушаалыг эрхэлж байгаа хугацаанд нь албан тушаалын цалингаас тооцож сар бүр олгоно.

3.3. Нэмэгдэл хөлсөнд шаардагдах хөрөнгийг тусгай хэрэгцээт боловсрол олгох төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан сургалтын байгууллагын төсөвт тусган санхүүжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 6 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

Хилийн заагийг тогтоох тухай

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Увс аймгийн Тэс сумын Тэсийн голын сав нутгийн байгалийн нөөц газрын болон Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Даян Дээрхийн байгалийн дурсгалт газрын хилийн заагийг хавсралт ёсоор тогтоосугай.

2. Эдгээр тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Байгаль, орны сайд И.Эрдэнэбаатар, Увс, Хөвсгөл аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД

И.ЭРДЭНЭБААТАР

Засгийн газрын 2006 оны 128 дугаар тогтоолын хавсралт

ТЭСИЙН ГОЛЫН САВ НУТГИЙН БАЙГАЛИЙН НӨӨЦ БОЛОН ДАЯН ДЭЭРХИЙН БАЙГАЛИЙН ДУРСГАЛТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ

Нэг. Тэсийн голын сав нутгийн байгалийн нөөц газар

Монгол Улсын хойд хилийн 129 дүгээр багана (93°08'45", 50°35'53"), түүнээс зүүн тийш улсын хилийн дагуу явсаар 156 дугаар багана (94°21'10", 50°31'30"), түүнээс баруун тийш Таван улиасны төв 855.1 тоот (94°05'27", 50°30'57"), түүнээс баруун тийш 818.1 тоот (93°49'17", 50°29'34"), түүнээс баруун тийш 794.9.0 тоот (93°32'34", 50°29'35"), түүнээс баруун урагш Хар-Үзүүрийн төв 774.8 тоот (93°21'51", 50°27'05"), түүнээс баруун урагш 772.4 тоот (93°16'36", 50°24'57"), баруун хойш дархан цаазат газрын хилийн дагуу 768.7 тоот (93°12'15", 50°25'13"), 764.0 тоот (93°10'30", 50°26'57"), 767.7 тоот (93°13'17", 50°29'42"), 762.9 тоот (93°11'54", 50°31'41"), 763.7 тоот (93°08'57", 50°34'04"), түүнээс хойш Монгол Улсын хойд хилийн 129 дүгээр багана (93°08'45", 50°35'53").

цэг болох Суварга уул 1616.2 тоот /101°52'42", 50°33'36"/, түүнээс зүүн хойш Сумангийн өндөр 1702.0 /101°57'13", 50°37'4"/, түүнээс зүүн хойш Хайрхандаваа 1385.0 тоот /102°2'32", 50°40'41"/, түүнээс зүүн тийш 1971.0 тоот /102°7'39", 50°40'11"/, түүнээс урагш 1988.0 тоот /102°8'42", 50°39'36"/, түүнээс зүүн урагш 1976.0 /102°11'30", 50°39'8"/, 1904.0 /102°12'45", 50°37'57"/ тоот өндөрлөгүүдийг дайруулан Улсын хил дээрх Нашит овоо 1972.1 тоот /102°16'19", 50°35'57"/, түүнээс баруун урагш Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдын хилийн заагийг даган 1895.5 тоот /102°12'30", 50°35'51"/, Дүмбэн уул 1991.2 /102°8'31", 50°34'50"/, 1965.0 /102°7'41", 50°33'36"/, Тэвхэр асра 1973.8 /102°4'15", 50°31'50"/ тоот өндөрлөгүүдийг дайран 1885.4 тоот /102°2'3", 50°29'59"/, түүнээс баруун хойш орших /101°53'00", 50°26'50"/ солбицол бүхий цэг, түүнээс баруун тийш /101°50'20", 50°26'50"/ солбицол бүхий цэг, түүнээс баруун урагш Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдын хилийн заагт орших 1808.9 тоот /101°57'13", 50°28'43"/, түүнээс баруун тийш мөн сумдын хилийн заагийг даган Малхын булгийн эхийг дайран баруун урд зүгт орших 1499.2 тоот /101°52'17", 50°28'27"/, түүнээс чанх хойшоо Суварга уул 1616.2 тоот өндөрлөг /101°52'42", 50°33'36"/.

Хоёр. Даян Дээрхийн байгалийн дурсгалт газар

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын нутагт орших Даян Дээрхийн агуй орчмын хамгийн баруун

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 6 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

худалдааны яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД

Б.ЖАРГАЛСАЙХАН

Бат-Ундрахын Нямсүрэнг Үйлдвэр,

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 6 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.2, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд заасны дагуу орон сууцны хөлс төлөх, түлээ, нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 50000 төгрөгөөр; Монгол Улсын болон хөдөлмөрийн баатар, ардын цолтон, ахмад дайчин болон дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр (нөхөр)-т улирал бүр олгох мөнгөн тусламжийн хэмжээг 50000 төгрөгөөр; Монгол Улсын гавьяат болон төрийн соёрхолт, Улсын ударник, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, "Алдарт эх" I одонтой ахмад настанд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 100000

төгрөгөөр, "Алдарт эх" II одонтой ахмад настанд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 50000 төгрөгөөр, ядуу амьдралтай, хөдөлмөрийн чадвартай гишүүнгүй, насанд хүрсэн бүрэн хараагүй иргэнтэй ерхийн суурин телефон утасны төлбөрт сар бүр үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээг 10000 төгрөгөөр тус тус тогтоож 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Тэтгэмж, тусламжийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2002 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 262 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Л.ОДОНЧИМЭД

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн Хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ :

1. Хөдөлмөрийн тухай хуулийн (цаашид хууль гэх) 14 дүгээр зүйлийн 14.2.-т заасан "хамтын нэг гэрээ байгуулна" гэдгийг улсын бүртгэлд бүртгүүлсэн, иргэний эрх зүйн чадвартай, эд хөрөнгө санхүүгийн нэг удирдлагатай, хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулж байгаа хуулийн этгээдийн дотоод зохион байгуулалтын бүтцэд хамаарах нэгж, хэсэг /газар, хэлтэс, тасаг, алба, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар, үйлдвэрийн цех гэх мэт/ нь

хамтын гэрээг тус тусдаа байгуулахгүй, харин нэгдсэн нэг гэрээ байгуулна гэж ойлгоно.

2. Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.-т заасан "хөдөлмөрийн гэрээний гол нөхцлийн аль нэгийг тохироогүй бол" гэдэгт мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.-д заасан нөхцлийн аль нэгийн талаар ажил олгогч болон ажилтан амаар тохиролцон ажил үүрэг гүйцэтгэж байсныг хамааруулахгүй.

Ажил олгогч хөдөлмөрийн гэрээ байгуулахгүйгээр ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлсэн тохиолдолд тэдний хоорондох маргааныг Хөдөлмөрийн тухай хуулийг баримтлан шийдвэрлэх бөгөөд харин хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй нь ажилтны буруугаас болсон нь тогтоогдвол маргааныг Иргэний хуулийн /369 дүгээр зүйлийн 369.3., гэм хор, гэх мэт/ дагуу шийдвэрлэнэ.

3. Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6.-д заасан **"бусад нөхцөл"** гэдэгт мөн зүйлийн 21.1.-д заасан **"гол нөхцөл"**-өөс бусад буюу хөдөлмөрийн гэрээний болон ажил үүрэг гүйцэтгэж эхлэх хугацаа, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, бүх төрлийн хөнгөлөлт, тэтгэмж, тэдгээрийг олгох нөхцөл, журам, ажил, амралтын цаг, тэдгээрийн үргэлжлэх хугацаа, хөдөлмөрийн сахилга, эд хөрөнгийн хариуцлага, ажилтны эрх зүйн болон хувийн байдлын онцлог /тухайлбал, эмэгтэй, насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй, одой хүмүүсийн болон ахмад настны, гадаадын иргэн, харьяалалгүй хүний хөдөлмөр гэх мэт /-той холбоотой асуудлын талаар талуудын харилцан тохиролцсоныг хамааруулан ойлгоно.

4. Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7.-д заасан **"гарын үсэг зурсан"** гэдэгт бичгээр байгуулсан хөдөлмөрийн гэрээнд ажил олгогч иргэн, ажил олгогч хуулийн этгээд, байгууллагыг төлөөлж, эрх бүхий албан тушаалтан, мөн ажилд орохыг хүссэн эрх зүйн чадамж бүхий иргэн өөрөө гарын үсэг зурсан байхыг хэлнэ.

Ажилтан болон ажил олгогч амаар тохиролцсоны дагуу ажилтан ажил үүргээ гүйцэтгэж эхэлсэн ба хөдөлмөрийн гэрээг бичгээр нөхөн байгуулахаар харилцан тохиролцсон нөхцөлд хөдөлмөрийн эрхийн харилцааг амаар тохиролцсон үеэс эхэлсэн гэж тооцож болно.

5. Хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.-д заасан **"өмчлөгч буюу түүнээс эрх олгогдсон этгээд"** гэдэгт Иргэний хуулийн 99 дүгээр зүйлд заасан өмчийн бүх төрөл, хэлбэрийн хуулийн этгээд, байгууллага, тэдгээрийн төлөөлөгч хамаарна.

Харин мөн зүйлийн 22.2.-т заасан **"контракт байгуулж, иргэнийг авч ажиллуулж болох ажил, албан тушаалын жагсаалт"** нь төрийн болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд, байгууллага, төрийн бус байгууллагад хамааралтай ба өмчийн бусад төрлийн хуулийн этгээд, байгууллагын хувьд энэ жагсаалтанд ороогүй байдал нь контракт байгуулахад саад болохгүй.

6. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.-д заасан **"хугацаатай гэрээ"** гэдэг нь хөдөлмөрийн гэрээний үргэлжлэх хугацааг хуангийн он, сар, өдрөөр, эсхүл

жил, улирал, сараар, үйл явдлаар /тухайлбал: ажил албан тушаал нь хэвээр хадгалагдаж буй ажилтан эргэж ажилдаа ортол гэх мэт/ тодорхойлогдсон байна. Энэхүү гэрээний хугацааг тоолохдоо Иргэний хуулийн хугацаа тоолох журмыг хэрэглэнэ.

7. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1.-д зааснаар ажил олгогч байнгын ажлын байранд ажиллах иргэнтэй хөдөлмөрийн **"хугацаагүй"** гэрээ байгуулах үүрэгтэй болно.

Харин энэ зүйлийн 23.2.2.-т дээрх гэрээг **"талууд харилцан тохиролцсоноор хугацаатай"** байгуулж болохоор заасан нь ажилтан, ажил олгогчийн хэн алины санаачилгаар, тэдгээрийн харилцан тохиролцооны үндсэн дээр, тодорхой үндэслэл, шаардлага үүссэн тохиолдолд хамаарна. Энэ нөхцөлд тухайн шаардлага, шалтгааныг, мөн талуудын хүсэл зоригийн илэрхийлэлийг хөдөлмөрийн гэрээнд зайлшгүй тодорхой тусгасан байвал зохино.

8. Хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.-д заасанаар контрактыг бичгийн хэлбэрээр байгуулахдаа энэ зүйлд заасан агуулгын шаардлагыг заавал хангана.

8.1. Хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.-т заасан **"ажилтны мэдэлд олгож буй хөрөнгийн хэмжээ"** нь контракт байгуулж байгаа ажил олгогчоос ажилтанд хүлээлгэн өгсөн, өмчлөгчөөс олгогдсон эрхийн хүрээнд захиран зарцуулж болох үндсэн болон эргэлтийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн тайлан баланс, данс бүртгэлд туссан дүнгээр тодорхойлогдож, санхүүгийн бичиг баримтуудаар баталгаажсан байна.

8.2. Мөн хэсэг дэх **"түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам"**-д ажилтанд олгосон хөрөнгийг ямар үйл ажиллагаанд зориулж, хэрхэн ашиглах, ямар арга, хэлбэрээр захиран зарцуулахыг өмчлөгч буюу түүнээс эрх олгогдсон этгээд контракт байгуулах үедээ тогтоох ба энэ тухай контрактдаа тодорхой тусгасан байвал зохино.

8.3. Мөн хэсэг дэх **"түүнд хүлээлгэх хариуцлага"** гэдэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлд заасан сахилгын шийтгэл,

134, 135 дугаар зүйлд заасан эд хөрөнгийн хязгаарлагдмал ба бүрэн хариуцлага хамаарах бөгөөд ажилтан контрактад тусгагдсан үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй гэм буруутай байх нөхцлийн аль хэлбэрт нь сахилгын ямар шийтгэл ногдуулах болон бусад хариуцлагыг ямар хэмжээгээр хүлээлгэхийг талууд контрактаар тохиролцон тогтооно.

Түүнчлэн контрактаар ажиллаж байгаа ажилтан Иргэний хууль тогтоомжийг зөрчсөнөөс өмчлөгчид учруулсан хохирлоо ямар хэмжээ, хэлбэрээр хариуцахыг талууд мөн адил тохирч, контрактад тусгаж болно.

9. Хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.-д заасан **"тохиролцсон"** гэдгийг тусад нь гэрээ байгуулах буюу хөдөлмөрийн гэрээнд нэмэлт оруулах зэргээр баталгаажуулна гэж ойлгоно.

10. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.-д заасан **"нэг гэр бүлийн хүмүүс"** гэдэгт Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4.-т заасан гэр бүлийн гишүүдээс гадна гэрлэлтийн баталгаагүй боловч хамтын амьдралтай хүмүүсийг хамааруулан ойлгоно.

Мөн хэсгийн **"торол, садангийн хүмүүс"** гэдэгт Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5., 3.1.6.-д заасан хүмүүс хамаарна.

11. Хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.-д заасан **"ажил, албан тушаалыг хэвээр хадгалах"** гэдэг нь энэ хэсэгт заасан үндэслэл, шалтгаан арилсан буюу хугацаа дууссаны дараа ажилтан урьд нь ажиллаж байсан ажил, албан тушаалд үргэлжлүүлэн ажиллах хүсэлт гаргасан тохиолдолд ажил олгогч тухайн ажил, албан тушаалд түүнийг ажиллуулах үүрэгтэй байхыг хэлнэ. Энэхүү хүсэлтийг ажил олгогч хүлээж аваагүйгээс үүссэн маргааныг энэ хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.2.-т заасан гомдолтой адилтган шүүх хянаж шийдвэрлэнэ.

12. Хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1.-д заасан **"эдгэрсэн"** гэдгийг эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс тодорхойлно.

13. Хуулийн 36 дугаар зүйлийн 36.2.-т заасан **"адил чанарын өөр ажил, албан тушаал"** гэдэгт

цөмхөтөгдсөн ажлын байр, албан тушаалын тодорхойлолт, цалингийн хэмжээ, хөдөлмөрийн үндсэн нөхцөлтэй ижил эсхүл ойролцоо түвшингийн ажлын байр, албан тушаалыг ойлгоно.

14. Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.-д заасан **"хөдөлмөрийн гэрээг цуцлах ажилтны өргөдөл"** гэдэгт ажил олгогчийн шахалт шаардлага, зүй бус нөлөөлөл зэрэг хөндлөнгийн оролцоогүйгээр хугацаатай ба хугацаагүй хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай ажилтнаас зөвхөн өөрийн хүсэл зоригийн дагуу, сайн дурын үндсэн дээр гаргасан бичгийн хүсэлтийг хэлнэ.

15. Хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар цуцлахад хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.-д заасан үндэслэлүүдийн аль нэгийг заавал баримталсан байвал зохино.

Ажил олгогч нь хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгохдоо үндэслэлээ тодорхой заасан, хөдөлмөрийн болон холбогдох бусад хуулийг баримталсан шийдвэр/тушаал, тогтоол, захирамж/ гаргана.

Ажлаас халсан тухай шийдвэр гаргаагүй атлаа ажилтны ажил үүргийг нь гүйцэтгүүлээгүй бол тухайн үеийн цалин хөлстэй тэнцэх олговрыг ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.-д заасны дагуу ажилтанд олгоно.

15.1.1. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1.-д заасан **"орон тоо хасагдсан"** гэдэгт тухайн хуулийн этгээд, байгууллагын зохион байгуулалтын бүтцээс тодорхой ажил, албан тушаалын ажлын байр үгүй болсныг ойлговол зохино. Энэ тохиолдолд ажил олгогч зөвхөн хасагдсан орон тооны ажлын байранд ажиллаж байгаа ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцална.

15.1.2. Мөн хэсэгт заасан **"орон тоо цөөрүүлэх"** гэдэгт хуулийн этгээд, байгууллагын зохион байгуулалтын бүтцийн адил ажил, албан тушаалын хэд хэдэн орон тооноос тодорхой тооны орон тоог хассаныг ойлгоно.

15.2. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2.-т заасан **"ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон"** гэдгийг ажилтны энэ байдлын талаар салбарын буюу тухайн байгууллагын мэргэжил, ур чадварын

түвшин тогтоох комисс, аттестатчиллын комисс болон эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын албан ёсны дүгнэлт, шийдвэр гарсан байхыг ойлгоно.

Харин хуульд өөрөөр заагаагүй бол боловсролын үнэмлэхгүй буюу дээд боловсролгүй гэх зэрэг шалтгаан нь ажил олгогчоос ажилтныг мэргэжил, ур чадварын хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй гэж үзэх, түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

15.3. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3.-т заасан **"ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн"** гэдэг нь ажилтан иргэний үнэмлэхийн үндсэн дээр он, сар, өдрөөр тоолоход 60 насанд бүрэн хүрсэн байхыг ойлгоно.

15.4. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4.-т заасан **"ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан"** гэдэгт хөдөлмөрийн сахилгын зөрчлийг 2 буюу түүнээс дээш удаа гаргасан байхыг ойлгоно. Зөрчил бүр тус тусдаа тогтоогдсон байх шаардлагатай боловч тус бүрд нь сахилгын шийтгэл заавал ногдуулсан байхыг шаардахгүй.

15.4.1. Давтан гаргасан зөрчлүүдийн хоорондох хугацаа өмнөх зөрчилдөө сахилгын шийтгэл хүлээсэн бол 1 жилээс, хүлээгээгүй бол 6 сараас хэтрээгүй байна.

15.4.2. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4.-т заасан **"ноцтой зөрчил"** гэдгийг ажил олгогчид эд хөрөнгийн хохирол учруулах, бизнесийн ба ажил хэргийн нэр хүндийг нь гутаах зэргээр түүнийг эрх, ашиг сонирхолд нь нөлөөлөхүйц сөрөг үр дагаварыг буй болгосон, үр ажилтны хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэгт нь харш үйлдэл, эс үйлдэл байна гэж ойлговол зохино. Гэрээний талууд ажлын байр, албан тушаал, гүйцэтгэх ажил үүргийн онцлогтой холбогдуулан ямар зөрчлийг ноцтой гэж тооцохыг харилцан тохиролцон тогтоож, үг зөрчлийн тохиолдол бүрийг хөдөлмөрийн гэрээнд нэрлэн заасан байна.

15.5. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5.-д заасан **"ажил олгогчийн итгэлийг алдсан ажилтны гаргасан буруутай үйлдэл, эс үйлдэхүй"**

нь хууль, санхүүгийн болон хяналтын зэрэг эрх бүхий байгууллагын шалгалт, мөн ажил олгогчийн дотоодын хяналт шалгалтаар тогтоогдсон байвал зохино.

15.5.1. Мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтны гаргасан эд хөрөнгийн зөрчил нь эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж тогтоогдсон нь эд хөрөнгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

15.5.2. Мөн хэсгийн **"мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан"** гэдэгт ажил олгогчийн мэдлийн өмч хөрөнгийг бүртгэн авч, бүрэн бүтэн байдлыг хангах, хадгалах, хамгаалах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бусдад шилжүүлэх үүрэг хүлээсэн эд хариуцагч байхаас гадна тодорхой зориулалт, чиглэлээр эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх мэдлийг өмчлөгчөөс шилжүүлэн авсан удирдах албан тушаалтан, мөн удирдах албан тушаалтантай зохих хэмжээгээр эд хөрөнгийг хамтран захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлж, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтанд бүртгэлээр хяналт тавих эрх бүхий санхүүгийн албан тушаалтан зэргийг хамруулан ойлгоно.

15.6. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6.-д заасан **"сонгууль томилолтоор өөр орон тооны ажил, албан тушаалд ажиллах болсон"** гэдэгт ажилтан өөр эсхүл тухайн байгууллагад орон тооны, тогтмол цалинтай ажилд зохих журмаар сонгогдох буюу томилогдохыг хэлнэ.

15.7. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.7.-д заасан **"контрактад заасан үндэслэл буй болсон"** гэдэгт хөдөлмөрийн харилцааг шууд зогсоож, түүнийг цуцлах талаар ажил олгогч ажилтантай байгуулсан контрактад тохирсон үндэслэлүүдийн аль нэг нь бий болсон байхыг ойлгоно.

16. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.-т заасан **"боллоцсооны дагуу өөр ажил олж өгнө"** гэсэн заалт нь хөдөлмөрийн гэрээ нь цуцлагдаж байгаа шинээр томилогдсон ажилтны зөвшөөрлөөр, хуулийн этгээд байгууллагын зохион байгуулалтын бүтцэд ажлын байр байгаа нөхцөлд хэрэгжих боломжтой гэж үзнэ.

17. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5.-д заасан **"сарын өмнө мэдэгдэх"**, **"45 хоногийн өмнө мэдэгдэх"**, мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.-т заасан **"ажилтанд 2 сар түүнээс дээш хугацааны өмнө мэдэгдэх"** тухай заалтуудыг хэрэгжүүлэхдээ хөдөлмөрийн гэрээг өөрийн санаачилгаар цуцлах тухайгаа ажил олгогч нь ажилтанд уг хугацааны өмнө бичгийн хэлбэрээр мэдэгдэж, гарын үсэг зуруулж, баталгаажуулна.

18. Хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1.-д заасан **"контрактад заасан хийвэл зохих ажлынхаа үр дүнг хүндэтгэх шалтгаангүйгээр хангаагүй буюу хангалттай ажиллаж чадаагүй"** гэдгийг тогтоож, ажилтны контрактаар хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэхдээ өмчлөгч буюу түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд нь контрактанд тусгасан журмыг баримталж, ажилтныг байцлуулах үүрэгтэй ба хуулийн энэ зохицуулалтыг контрактанд тусгасан үр дүн гараагүй байдал нь ажилтны өөрөөс хамаарах шалтгаанаар ажил үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хамааруулан ойлгоно.

Контрактын эцсийн үр дүн бодитой гараагүй, үүрэг биелэгдээгүй болох нь баримтаар тогтоогдсон байх бөгөөд энэ тухай дүгнэлтийг ажилтанд танилцуулан, гарын үсэг зуруулж, уг дүгнэлтийг ажилтан эс зөвшөөрвөл түүний тайлбарыг хавсаргасан байна.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой / хөрөнгийн 51 буюу түүнээс дээш хувьтай / хуулийн этгээд болон түүний ерөнхий менежерийн хооронд байгуулсан үр дүнгийн гэрээг контрактын нэгэн адил үзнэ.

19. Хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.-т заасан **"ажлаас халагдсан өдөр"** -ийг ажил олгогчийн шийдвэр /тушаал, захирамж гэх мэт/-т заахдаа тухайн ажилтны ажилласан хугацаанд нь өнөгдвол зохих ээлжийн амралтын хоногийг урьдчилан тооцож, түүн дээр ажил хүлээлцэхэд зориулж тогтоосон хоногийг нэмж, сүүлчийн өдрийг тогтооно.

Ажил олгогчийн шийдвэр /тушаал, захирамж гэх мэт/-т заасан хугацаа **ажилтны буруугаас** хэтэрвэл уг шийдвэр /тушаал, захирамж гэх мэт/-т заасан өдрийг, харин **ажил олгогчийн буруугаас** хэтэрвэл ажил хүлээлцэн өгсөн өдрийг тус тус ажил хүлээлцэн өгсөн сүүлчийн өдөр гэж үзнэ.

20. Хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.-д заасан **"нийтээр амрах баярын өдөр ажилласан"**, 53 дугаар зүйлийн 53.1.-д заасан **"долоо хоногийн амралтын өдөр ажилласан"** гэдэгт ээлжийн графикаар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтны ээлж амралтын өдөр таарахыг хамааруулахгүй.

21. Хуулийн 79 дүгээр зүйлийн 79.5, 79.6.-д заасан нэмэгдэл амралтыг хөдөлмөрийн хэд хэдэн нөхцөлд ажилласан ажилтанд олгохдоо **"хэвийн"** болон **"хэвийн бус"** нөхцөлд ажилласан хугацааг тус тусад нь тооцож, нэмэгдэл амралтын нийт өдрийг нэмж гаргана.

Мөн зүйлийн 79.5.1.-79.5.6., 79.6.1.-79.6.6.-д тус тус заасан **"жилд"** гэснийг тухайн "жил дуустал" гэж ойлгоно. Тухайлбал: **"6 - 10 жил ажлын 3 өдөр нэмэгдэл амралт олгоно"** гэдэгт анх ажилд орсон өдрөөс бүтэн жилий бүрэн, мөн 10 жил дууссан өдрөөр тоолно.

22. Хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.-д заасан **"ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангана"** гэснийг үнэ төлбөргүй олгоно гэж ойлгоно.

23. Хуулийн 97 дугаар зүйлийн 97.1., 97.1.2.-т заасан **"ар гэр"** гэдэгт нас барсан ажилтантай нэг ам бүлд хамтран амьдарч байсан гэр бүлийн гишүүд, төрөл садангийн хүмүүс хамаарна.

24. Хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.1.-д заасан **"цалингийн дундажтай тэнцэх хэмжээний нохон төлбөр"**, 97 дугаар зүйлийн 97.1.2.-т заасан **"цалинтай тэнцэх хэмжээний нохон төлбөр"**-ийг хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.-д заасан **цалин хөлснөөс тооцно.**

25. Хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.1., 97.1.2.-т заасан **"нохон төлбөр"** -ийг 1999 оны 7

дугаар сарын 1-ний өдрөөс хойш үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчилсөн, мөн уг хугацаанаас өмнө эдгээр тохиолдолд өртөж, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр гараагүй байгаа болон комиссын шийдвэр гарсан боловч нөхөн төлбөр аваагүй байгаа хүмүүст хамааруулан ойлгоно.

25.1. Ажил олгогч энэ хэсэгт заасан хугацааны нөхөн төлбөрийг **"нэг ба түүнээс дээш удаа олгоно"** гэдэг нь нэг удаа заавал олгохыг эхлэх ба хөдөлмөрийн чадвар алдалтын хувь багассан, нэмэгдсэн тохиолдолд нэгээс дээш удаа олгоно

Хөдөлмөрийн чадвар алдагдалтын хэмжээ өөрчлөгдөөгүй боловч нөхөн төлбөрийг ажил олгогч нэгээс дээш удаа олгосон тохиолдолд хууль зөрчсөн гэж үзэхгүй.

25.2. Мөн зүйлийн 97.1.1.-д заасан нөхөн төлбөрийг ажилтанд олгосон явдал нь 97.1.2.-т заасан үндэслэлээр нас барсан ажилтны ар гэрт нөхөн төлбөр олгоход саад болохгүй.

26. Хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2., 109.3.-т зааснаар ажил олгогч нь 14-15 насны иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа тэдний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн байцаагчийн зөвшөөрлийг бичгээр авч, энэ тухай гэрээнд тэмдэглэвэл зохино.

27. Ажлаас буруу халсан, өөр ажилд буруу шилжүүлсэнтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг шүүх хянан шийдвэрлэхдээ тухайн ажилтны эрх зүйн байдлаас хамааран Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.2., 69 дүгээр зүйлийн 69.1., Төрийн албаны тухай болон бусад хуулийн холбогдох заалтуудыг баримталж байвал зохино.

Ажилтныг захиргааны санаачлагаар ажлаас үндэслэлгүй халснаас байгууллагад учирсан хохиролыг гэм буруутай этгээдээс гаргуулах асуудлыг бие даасан нэхэмжлэлээр шийдвэрлэнэ.

28. Хуулийн 129 дүгээр зүйлийн 129.3.-т заасан **"хүндэтгэн үзэх шалтгаан"** гэдэгт энэ

зүйлд заасан хугацааны дотор гомдол гаргагч хүндээр өвчилсөн, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон зэрэг өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар гомдол гаргах боломжгүй байсан байдлыг ойлгоно. Харин хууль мэдэхгүй явдал нь хүндэтгэн үзэх шалтгаан болохгүй.

29. Хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1.-д заасан сахилгын шийтгэл нь ажилтны гэм буруу, зөрчлийн шинж чанар, үр дагаварт тохирсон байх бөгөөд шийтгэлийг заавал шат дараалан оногдуулсан байхыг шаардахгүй.

30. Хуулийн 136 дугаар зүйлийн 136.3.-т заасан **"хэд хэдэн ажилтны буруугаас учирсан хохирлын хэмжээг тэдгээрийн гэм буруугийн хэмжээ, эд хөрөнгийн хариуцлагын төрлийг харгалзан ажилтан тус бүрээр тодорхойлно"** гэснийг хамтын удирдлагатай хуулийн этгээдийн удирдлагын эрх мэдлийг хэрэгжүүлдэг /зөвлөл, тэргүүлэгчид гэх мэт/ албан тушаалтнуудын хамтран гаргасан хууль бус шийдвэрийн улмаас тухайн хуулийн этгээдэд учирсан хохирлыг арилгах үед нэгэн адил хэрэглэнэ.

31. Ажил олгогч Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж зөрчиж, ажилтны эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хохироож байгаа нь тогтоогдвол шүүх хэрэг хянан шийдвэрлэх явцдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 141 дүгээр зүйлд заасан захиргааны шийтгэлийг өөрийн санаачлагаар ногдуулна. Харин энэ зүйлийн 141.3.-т заасан алдангийг нэхэмжлэлийн шаардлага гаргасан тохиолдолд Иргэний хуулийн 232 дугаар зүйлд заасан хэмжээ, журмын дагуу шийдвэрлэнэ.

32. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2000 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 259 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ Д.ТУНГАЛАГ

ШҮҮГЧ Б.УНДРАХ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.18, 9.2.19 дахь заалтыг тайлбарлах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.18, 9.2.19 дахь заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн зарим заалтыг дор дурдснаар тайлбарласугай.

1. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.18.-д заасан "дотоодын программ хангамжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээс худалдан авсан бараа" гэдэгт Монгол улсад үйлдвэрлэгдсэн,

дотоодын зах зээлд борлуулагдаж байгаа, зөвхөн программ хангамжийн бүтээгдэхүүн хамаарна.

2. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.19.-д "импортоор нийлүүлж байгаа компьютер, принтер, скайнер тэдгээрийн эд ангиуд" гэдэгт Монгол улсад импортоор нийлүүлсэн дотоодын зах зээлд борлуулагдаж байгаа компьютер, принтер, скайнер, тэдгээрийн эд ангиудыг хамааруулан ойлгоно.

Харин импортоор нийлүүлсэн боловч дотоодын зах зээлд борлуулахгүй экспортод гаргасан компьютер, принтер, скайнер, тэдгээрийн эд ангиуд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх бараанд хамаарахгүй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
С.БАТДЭЛГЭР
ШҮҮГЧ
А.ДОРЖГОТОВ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 114, 115 дугаар зүйлүүдийн зарим заалтыг тайлбарлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ 114 дүгээр зүйлийн 114.1.3 дахь хэсгийн "тахир дутуугийн зэрэгт оруулах шаардлагатай ялтны тодорхойлолтыг эрүүл мэндийн зохих байгууллагад гаргах"; 115 дугаар зүйлийн 115.1.8 дахь хэсгийн "урьд тогтоолгосон өндөр насны болон бусад тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах" гэсэн заалтуудыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Хуулийн 114 дүгээр зүйлийн 114.1.3 дахь хэсгийн "... ялтны тодорхойлолт ..." гэдэгт ялтны хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоохтой холбогдсон түүний өвчин, эмгэгийн байдал, анатоми, морфологи, үйл ажиллагааны өөрчлөлт, алдагдал, бие махбод, мэдрэлийн системийн онцлогийн талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Тогтоол гүйцэтгэх газрын нэгдсэн эмнэлгийн эмч нарын зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийг хэлнэ.

2. Мөн зүйл, хэсгийн "... эрүүл мэндийн зохих байгууллага ..." гэдэгт өвчтэй тухайн ялтны

*Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол улсын хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2005 оны №22, 470 дугаар тал

ял эдэлж байгаа хорих ангийн харьяалагдах аймаг, нийслэл, сум, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх "эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс"-ийг ойлгоно.

3. Хуулийн 115 дугаар зүйлийн 115.1.8 дахь хэсгийн "... бусад тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах" гэдэгт шүүхийн шийтгэх тогтоол гарч, хорих ял эдлэхээс өмнө ялтан Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан болзол, журмын дагуу нийгмийн даатгалд даатгуулж, шимтгэл төлсөн, тэтгэвэр, тэтгэмж авах эрх нь үүссэн, тэтгэвэр, тэтгэмжээ авч байсныг хамааруулна.

4. Мөн зүйл, хэсгийн "... бусад тэтгэвэр ..." гэдэгт Нийгмийн даатгалын сангаас авах тахир

дутуугийн, тэжээгчээ алдсаны, ахмад настны халамжийн, дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх /50 насанд хүрсэн эцэг/-ийн халамжийн тэтгэвэр тус тус хамаарна.

5. Мөн зүйл, хэсгийн "... бусад тэтгэмж" гэдэгт Нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, мөн нийгмийн халамжийн сангаас хөхүүл хүүхэдтэй эхэд олгох, түүнчлэн жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй эхэд олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тус тус хамааруулан ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
С.БАТДЭЛГЭР
ТАНХИМЫН ТЭРГҮҮН
О.ЗАНДРАА

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсгийн "Казиногийн үйл ажиллагаа эрхлэх"-ийг хориглох гэдэгт мөнгө буюу түүнийг орлогч металл (токенс) хэрэглэн тоглодог электрон

хэрэгсэл, слот машин, мөн тоглоомын үйл ажиллагаанд мөнгийг орлуулан хэрэглэх зориулалтын тусгай хуванцар зоос (чип) буюу шоо, хөзөр, гэдгээрт зориулсан тоглоомын тусгай ширээ зэрэг казиногийн зориулалтаар өрөө, тасалгаа, тоног, төхөөрөмжийг ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршсан тоглоом тоглуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
С.БАТДЭЛГЭР
ТАНХИМЫН ТЭРГҮҮН
О.ЗАНДРАА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэлэлцэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265058
Индекс: 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 4.5